

# MONGOLIAN ECONOMY

2014 ОНЫ 7 САР. №13 (071)

ТЭД ЭДИЙН ЗАСГИЙГ ХЭРХЭН ДҮГНЭВ



**P22** Д.Бямбасүрэн:  
Төр ард түмэн рүү нүүрээ  
харуулсан бодлого  
явуулах хэрэгтэй байна.



**P28** Ч.Ганхуяг:  
Хувьчлалыг эдийн засаг  
хөгжиж, хүмүүс сонирхсон,  
мөнгөтэй байх үед явуулдаг.

WWW.MONGOLIANECONOMY.MN

## ХӨГЖЛИЙН ЗҮТГЭХ ХҮЧ





**summit**  
computer technology

Албан ёсны  
дистрибьютор

**EPSON**  
EXCEED YOUR VISION



# Epson EB-97 Projector



Wi-Fi\*



iProjection



Multi PC  
Connection



Horizontal  
Keystone  
Adjuster



HDMI




3-in-1  
USB Display




Power  
Savings


### Powerful 16W Speaker



### Wireless Transmission



### Multi-PC projection



### High Contrast Ratio

Up to  
**2700lm**  
Colour Light Output  
**10000:1**  
contrast



# ЧАДВАРЛАГ ХАМТ ОЛОН СҮҮЛИЙН ҮЕИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ ЧАНАРТАЙ БҮТЭЭЛ

Сэдэв



- ЭДИЙН ЗАСАГ
- НИЙГЭМ
- УЛС ТӨР
- ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ
- ХҮНИЙ ЭРХ
- ЭРХ ЧӨЛӨӨ
- БАНК
- САНХҮҮ
- УУЛ УУРХАЙ

Шийдэл



- СУРВАЛЖЛАГА
- НЭВТРҮҮЛЭГ
- ЯРИЛЦЛАГА
- ХЭЛЭЛЦҮҮЛЭГ
- РЕКЛАМ
- СУРТАЛЧИЛГАА
- ПРОМО
- ШТОРК

Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, VI хороо  
Их сургуулийн гудамж, АВ CENTER, 503 тоот

УТАС: 70115476  
70115477



Ногоон хөгжлийн төлөө

# MONGOLIAN ECONOMY

Монголын сэтгүүлдийн эвлэлийн  
“2013 оны Шилдэг сэтгүүл”

## ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:

Д.Бэхбаяр / 9999-4248

## ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:

И.Отгонжаргал / 8800-6228

## АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР:

Теренс Эдвардс

## ЗӨВЛӨХ МЭРГЭЖИЛТЭН:

Лиззи Хүү

## ОРЧУУЛАГЧ:

Р.Гантулга

## ВЭБ РЕДАКТОР:

Б.Энхцэцэг

## СЭТГҮҮЛЧИД:

Б.Баяртогтох

Э.Зоригт

Б.Үүрийнтуяа

С.Батзаяа

## ДИЗАЙНЕР:

Ш.Оюундарь

## МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР:

Д.Баринжав / 9409-2904

## БОРЛУУЛАЛТЫН МЕНЕЖЕР:

М.Хишигтогтох / 9409-2906

## “ECONOMY” ТВ СТУДИ

## СЭТГҮҮЛЧ:

Ц.Соёлмаа

## ЗУРАГЛААЧ:

Ш.Гантуул

## КОМПЬЮТЕР ГРАФИКЧ:

Т.Баярсайхан

## ХАЯГ:

Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг.

VI хороо, Их сургуулийн гудамж.

AB center. 503 тоот

15160 Улаанбаатар,

Төв шуудан, ш/ х-2762

[www.mongolianeconomy.mn](http://www.mongolianeconomy.mn)

[info@mongolianeconomy.mn](mailto:info@mongolianeconomy.mn)

Утас/Факс: 976 - 7011 5476

“Улаанбаатар принт” ХХК-д хэвлэв

[www.ubprint.mn](http://www.ubprint.mn)

РЕДАКЦИД  
ЗАХИАЛБАЛ  
ХҮРГЭЛТ  
ҮНЭГҮЙ



MONGOLIAN ECONOMY  
ОНЛАЙН СЭТГҮҮЛ  
[mongolianeconomy.imedia.mn](http://mongolianeconomy.imedia.mn)

## АГУУЛГА

### ЭДИЙН ЗАСАГ

- 8 Хувийн хэвшил төрөөс том байхын учир
- 10 Салхи эргэлээ
- 14 Герман чанар Монголд
- 15 Монголыг мөнгөтэй болгох “Алтанбулаг”-ийн чөлөөт бүс
- 17 Эрчим хүчний шинэ эх үүсвэр барианы зүг
- 18 Зочдын хөлд дарагдсан сар
- 20 Си Зиньпин: Хамтдаа хожих ёстой



- 21 В.В.Путин ба хийн хоолой
- 22 Д.Бямбасүрэн: УИХ, Засгийн газар, Төвбанк хямралын үүсгүүр генератор болоод байна
- 26 Өрөнд найдаж суухгүй болно
- 28 Ч.Ганхуяг: Бид Африкийн замаар орчихлоо. Үүний гарц нь улстөрийн шийдэл
- 32 Газар өмчлүүлэхэд бэлэн үү
- 33 “Хил хязгааргүй” салбарын далавч



- 36 Хүмүүн цадиг

### НОГООН ЭДИЙН ЗАСАГ

- 38 Бидний хүсэж буй ирээдүй

### “MONGOLIAN ECONOMY” СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Б.БЯМБАСАЙХАН Монголын бизнесийн зөвлөлийн ТУЗ-ийн дарга, “Mongolian Economy” сэтгүүлийн Зөвлөлийн тэргүүн

Б.БОЛД “Рио Тинто” компанийн Зэсийн группын Олон улсын үйл ажиллагаа эрхэлсэн Ерөнхийлөгч

С.БЭХБАТ ЭЗХЯ-ны Инноваци, төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга

Д.ЖАРГАЛСАЙХАН МIН группын ерөнхийлөгч

Ц.БАТСҮХ СЭЗДС-ийн Эдийн засгийн тэнхимийн эрхлэгч

Ж.СҮНЖИДМАА “Пийбоди Энержи” компанийн Монгол дахь хамтын ажиллагаа, олон нийтийн асуудал хариуцсан менежер

Б.ТҮВШИНТӨГС Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал

#### Борлуулах цэгүүд:

- “Интер ном”
- “Цэцэг төв”
- “Минж плаза”
- “Алтантүлхүүр” номын дэлгүүр
- “Номин” супермаркетийн бүх салбар
- “Макс” супермаркетийн бүх салбар
- “Фреско” супермаркет
- BTSI супермаркет
- “Аз орчлон” номын дэлгүүр
- “Билэг” их дэлгүүрийн номын тасаг
- “Гранд Плаза” дахь супермаркет
- “Мир” номын дэлгүүрийн
- “Grand plaza”
- “Metro mall”
- “Sky” супермаркет
- “Улаанбаатар” их дэлгүүр дэх салбар
- “Max mall” салбарууд

 [facebook.com/Mongolian.Economy](https://facebook.com/Mongolian.Economy)

 [twitter.com/EconomyMongolia](https://twitter.com/EconomyMongolia)

 [youtube.com/user/MongolianEconomy](https://youtube.com/user/MongolianEconomy)

## МОНГОЛД

### Хөрөнгө оруулалт:

Монгол Улсын Хөгжлийн банк ОХУ-ын Внешэконом банкттай 2022 он хүртэл 75 сая ам.долларын урт хугацаатай зээлийн гэрээ байгуулахаар боллоо.

Ингэснээр тус хөрөнгөөр IV Дулааны цахилгаан станцын хүчин чадлыг нэмэгдүүлж, шинээр суурилуулах 100 МВт-ын турбин генераторыг худалдан авах, суурилуулах ажлыг санхүүжүүлэх аж. Энэ оны зургадугаар сарын 25-ны байдлаар дээрх төсөлд 48.5 сая ам.долларын санхүүжилт олгоод байна.

### Эдийн засаг:

“Монгол Улсын макро эдийн засгийн төлөв байдал” сэдэвт дээд хэмжээний хурал өнгөрсөн сарын 25-нд Төрийн ордонд боллоо. Эдийн засгийн хөгжлийн яам, Монголбанк, Дэлхийн банк болон Олон улсын валютын сантай хамтран зохион байгуулсан тус хурлын хүндэт зочид Монгол Улсын өр 40-60 хувиар өссөн нь хөгжиж буй улсын хувьд өндөр үзүүлэлт болохыг анхааруулжээ. Тэдний зүгээс манайд Үнэ тогтворжуулах хөтөлбөрөө зогсоох, арилжааны банкуудын хяналтыг сайжруулах, төсвийн зарлагаа хумихыг санал болголоо.

### Хот:

Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний парк шинэчлэлтэд зориулан угсраа автобус 40, их багтаамжийн автобус 120, дунд багтаамжийн автобус 40 ширхэгийг тус тус урьдчилгаа төлбөр

төлөх нөхцөлтэйгээр худалдан авахаар болжээ. Энэхүү худалдан авалтад зарцуулах хөрөнгийг “Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх сан”-гаас гаргах аж.

### Уул уурхай:

“Эрдэнэс Тавантолгой” ХК хувьцаат компани БНХАУ-ын найман томоохон худалдан авагчтай нүүрс борлуулах гэрээ байгуулжээ. Тэдэнд нийт 4.25 сая тонн нүүрс нийлүүлэхээр тохиролцоод байгаа аж. Үүнийг багаар буюу уурхайн амны нөхцөлөөр нэг тонныг нь 35 ам.доллараар худалдана гэж тооцвол, ойрын үед 150-160 сая ам.долларын борлуулалтын орлого олох боломжтой аж. “Эрдэнэс Тавантолгой” компани нэг тонн нүүрсийг Уурхайн амны нөхцөлөөр 35 ам.доллараар, Цагаан хадны нөхцөлөөр 48.5 ам.доллараар, Ганц модны нөхцөлөөр бол 57 ам.доллараар худалдаж байна. Энэ онд тус компани 7.5 сая тонн нүүрс олборлож, долоон сая тонн нүүрс борлуулсан 250 сая ам.долларын орлого олохоор ажиллаж байгааг Уул уурхайн сайд Д.Ганхуяг хэллээ.

### Хөнгөн үйлдвэр:

Монгол Улсын ноолуурын салбарт ойролцоогоор 6000 ажилтан ажиллаж байгаа бөгөөд үүний 80-90 хувь нь эмэгтэйчүүд байна. Чингис бондын санхүүжилтээр тоног төхөөрөмж, хүчин чадлыг нэмэгдүүлснээр тус салбарт 300 орчим ажлын байр шинээр бий болжээ. Манай улсын хувьд жилдээ 7000 тонн ямааны түүхий ноолуураар эцсийн

бүтээгдэхүүн үйлдвэрлэх бүрэн боломжтой аж. Дэлхийн зах зээл дэх түүхий ноолуурын 25 хувийг Монгол Улс дангаар бэлтгэж буй. Үүний 85 хувь нь экспортын бүтээгдэхүүн, 15 хувийг дотооддоо боловсруулж байна.

### Сэргээгдэх эрчим хүч:

“Зүүн хойд Ази дахь сэргээгдэх эрчим хүчний хөгжил, “Говьтек ба Азийн супер сүлжээ санаачилга” сэдэвт “Эрчим хүчний Хартийн Улаанбаатарын форум” олон улсын хурал Улаанбаатар хотноо өнгөрсөн 26-нд боллоо. Тус хуралд ОХУ, БНХАУ, БНСУ, Японы төлөөлөл оролцсон юм. Азийн супер сүлжээ санаачилга нь Зүүн хойд Азийн улс орнуудын эрчим хүчний сүлжээг харилцан холбох зорилготой аж. Харин Говьтек санаачилга нь говийн бүсийн сэргээгдэх эрчим хүчний нөөцөөс цэвэр цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж, цахилгаан эрчим хүчний эрэлт ихтэй бүс нутгуудад уг эрчим хүчээ экспортлохоор зорьж буй.

### Аялал жуулчлал:

Эдийн засгийг эрчимжүүлэх 100 хоногийн ажлын хүрээнд Монгол Улсад иргэд нь визгүй зорчих 42 орны жагсаалтыг Засгийн газрын тогтоолоор баталж, өнгөрсөн сарын 25-наас хэрэгжиж эхлээд байна. Энэхүү шийдвэрийн дагуу жагсаалтад нэр дурдсан орны иргэд ирэх оны 12-дугаар сарын 31-ний өдрийг дуустал Монгол Улсад аялал жуулчлал,

бизнесийн зорилгоор 30 хүртэл хоногийн хугацаанд визгүй зорчих юм.

### Хүний хөгжил

НҮБ-ын Байгаль орчны Ассамблейн анхдугаар чуулган өнгөрсөн сарын 23-27-нд Кени улсын Найроби хотноо боллоо. Тус хуралд дэлхийн 170 гаруй орны төлөөлөгч оролцож, НҮБ-ын Байгаль Орчны Ассамблейн Ерөнхийлөгчөөр Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюун сонгогдлоо. “Хүн бүрд нэр төртэй амьдрах нөхцөлийг бүрдүүлэхийн төлөө” урин дор чуулсан өндөр дээд түвшний хуралдаан тогтвортой хөгжлийн зорилт, 2015 оноос хойшхи хөгжлийн зорилт болон зэрлэг амьтан, ургамлын хууль бус худалдаа зэрэг асуудлыг хэлэлцлээ.

### Бизнес:

ММС-ийн охин компани болох Mongolian Coal Corporation нь Risun Mining-тай хамтын хөрөнгө оруулалттай компани байгууллаа. Уг компани нь Хятадын “Tianjin Airport” эдийн засгийн бүсэд байгуулагдсан ба ММС-ийн бүтээгдэхүүнийг тээвэрлэх, борлуулах ажлыг талууд хамтран гүйцэтгэх аж. Mongolian Coal Corporation нь хамтын хөрөнгө оруулалттай компанийн 51 хувийг эзэмших бол 49 хувийг нь Risun Mining эзэмших юм. Шинээр байгуулагдсан компанийн нэр нь “Tianjin Zhengcheng Import and Export Trade” бөгөөд нийт хөрөнгө оруулалт нь 14 сая юань. ▶▶

## ДЭЛХИЙ ДАХИНД

### Дэлхийн банкууд

Banker сэтгүүл жил бүр дэлхийн топ 1,000 банкиг ашиг, хөрөнгийн хэмжээгээр нь шалгаруулдаг байна. Өнгөрсөн онд дэлхийн топ 1,000 банк 920 тэрбум ам.долларын ашиг олжээ. Энэ нь санхүүгийн хямралаас хойш хүчин чадал нь нэмэгдсэн болохыг харуулж буй. Харин БНХАУ-ын банкуудын татварын өмнөх нийт ашиг 292 тэрбум ам.доллар байсан нь дээрх 1,000 банкны олсон нийт ашгийн гуравны нэгийг эзэлсэн байна.

### Азийн хувьцааны зах зээл

Ам.доллар дарамтаас гарахгүй байгаа боловч Азийн хувьцааны зах зээл сүүлийн үед ялимгүй өссөн үзүүлэлттэй байна. Дэлхийн эдийн засгийн өсөлтийн талаарх хөрөнгө оруулагчдын найдварыг шалгах хагас жилийн эдийн засгийн үзүүлэлт удахгүй гарах гэж буй.

Сөүлийн индекс 0.7 хувь, Шанхай индекс 0.6 хувь, Японы Никкей индекс 0.4 хувийн тус тус өсөлттэй гарчээ. FTSE 100, DAX, CAC 40 зэрэг европын индексүүд ч мөн адил 0.1-ээс 0.3 хувийн өсөлттэй байв.

### Европын холбооны хориг хойшлогдов

Өнгөрсөн сарын 27-нд Европын холбооны зүгээс ОХУ-д тавих хориг хойшлогдов. Үүний өмнөхөн АНУ-ын топ хоёр лобби уг хоригийг АНУ-д сөргөөр нөлөөлнө хэмээн сурталчилгааны кампанит ажил явуулсан байна.

Мөн баруун Европын нэгэн орны төлөөлөл "Урьдчилсан зөвлөлгөөнөөс харахад өнөөдөр ОХУ-д худалдаа, эдийн засгийн хориг тавих шаардлагатай гэж үзэж буй удирдагч Европын холбооны орнуудад бараг л байхгүй болов уу" гэж Итар-Тасс агентлагт ярьжээ. Гэхдээ Украинд үүсээд буй нөхцөл байдал хүндэрч, хориг тавихаас өөр аргагүй байдалд орвол шаардлагатай хориг тавихаас өөр аргагүй юм. Үүний бэлтгэл ажлыг ч Европын албаны хүмүүс хангаад байгаа аж.

### БНХАУ


Хятадын хамгийн том интернэт худалдааны компани болох "Алибаба"

нь АНУ-д IPO гаргахаар Нью Йоркийн хөрөнгийн биржийг сонгосон талаар "Ройтерс" мэдээлэв. Энэ нь уг биржийн гол өрсөлдөгч болох Nasdaq-ийн төлөвлөгөөг нураажээ. "Алибаба" нь Хятадын интернэт жижиглэнгийн худалдааны 80 гаруй хувийг дангаар эзэлдэг том компани юм. Хувьцааныхаа товчилсон нэрийг BABA гэж нэрлэхээр болжээ. Хэрвээ уг IPO төсөвлөсөн хугацаандаа гарвал энэ нь 2012 онд 15 тэрбум ам.долларын хувьцаа гаргасан Facebook-ээс ч дээгүүр эрэмбэлэгдэж, АНУ-ын хамгийн том IPO болж магадгүй байна.

### ОХУ

ОХУ-ын метал, уул уурхайн

томоонохн компаниудын нэг болох "Мечел" групп энэ онд БНХАУ руу экспортолж буй нүүрсний хэмжээгээ 19 хувиар нэмэгдүүлж, 7.5 сая тонн болгох аж. Энэ талаар Итар-Тасс мэдээлсэн байна. Түүнчлэн Япон руу хийх экспортоо 42 хувиар нэмэгдүүлж, 1.85 сая тонн, БНСУ руу хийх экспортоо 43 хувиар нэмэгдүүлж, нэг сая тоннд хүргэхээр төлөвлөөд байгаа талаар тус компанийн гүйцэтгэх захирал Павел Штарк хэлжээ. "Мечел" компанийн урт хугацаанд байгуулсан гэрээний нэгж хувьцааны үнэ 32 цент бөгөөд нийт хувьцааны үнийн дүн нь бүх гэрээнийх нь гуравны нэгийг эзэлж буй. ■




Шог зургийг А.Амарсайхан

## ОНЦЛОХ

# ХУВИЙН ХЭВШИЛ ТӨРӨӨС ТОМ БАЙХЫН УЧИР

## И.ОТГОНЖАРГАЛ

“Mongolia Business Summit-2014”-д оролцсон дотоод, гадаадын хөрөнгө оруулагчид болон хувийн хэвшлийнхнийг Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж сайхан үгээр цэнэглэж, аугаа “эрч хүч” бэлэглэлээ. Ялангуяа дотоодын бизнес эрхлэгчдийн хувьд байнга тавьдаг санал шүүмжлэлийг нь төрийн нүд, чих сонсож бодлого шийдвэртээ тусгаж байгаа тухай төрийн тэргүүнээсээ дуулсан болохоор хүсэл мөрөөдөл нь биелэх шиг санагдаж, жигүүр ургах мэт болсон биз ээ. Тэр хүчтэй үгс юу байсан бэ? Сүүлийн үед нийгэмд хүчтэй яригдаад байсан ардчилсан чөлөөт зах зээлийн нийгэм дэх төрийн оролцоо хэрээс хэтэрч байгаа болон төр компани байгуулан хувийн хэвшлийн өрсөлдөгч болж байгаа тухай юм. Энэ талаар нийгмийн салаа мөчир бүрийн төлөөлөл жил бүрийн “Монголын эдийн засгийн чуулган” хийгээд холбогдох хурлуудын үеэр байнга санал гомдол тавьдаг. Тухайлбал, хамгийн наад захын жишээ гэхэд л Монголбанк Засгийн газар хамтарч “Үнэ тогтворжуулах дэд хөтөлбөр” хэрэгжүүлж байгаа нь буруу. Энэ нь чөлөөлт зах зээлд бизнесийн өрсөлдөөн шударга явж, зах зээл бараа бүтээгдэхүүний үнийг тогтоодог жаягийг гажуудуулж буй тухай шүүмжлэх нь бий. Түүнчлэн хувийн хэвшил зам тавьж, нүүрс зөөж байхад зэрэгцээд төр нүүрс экспортлох компани байгуулах жишээтэй. Төрийн оролцоо их байна гэдгийг зөвхөн бизнес эрхлэгчид хэлээд зогсохгүй бусад салбарын хүмүүсийн баримт судалгаа ч бишгүй. Жишээ нь, өнгөрсөн онд манай сэтгүүлийн том төрийн тухай тусгай дугаарт философич Ё.Энхбаяр “Төрийн оролцоо арай хэтэрлээ” гэсэн гарчигтай нийтлэлдээ “Нийгмийн амьдралд төрийн оролцоо ямар байгааг үнэлдэг хэд хэдэн аргачлал байдаг. Хамгийн энгийн арга бол улсын төсөв нийгмийн нийт баялгийн хэдэн хувь байна вэ гэдгээр тодорхойлох явдал юм. Өндөр хөгжсөн оронд улсын төсөв ДНБ-ий 30 хувиас хэтэрдэггүй. Монгол Улсын 2013 оны төсвийг аваад үзэхэд төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого 7,088.3 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 40.2 хувь, тэнцвэржүүлсэн орлогод нийцүүлсэн нэгдсэн төсвийн нийт зарлага 7,444.6 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 42.2 хувь, нэгдсэн төсвийн нийт тэнцэл 356.3 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу ДНБ-ий 2.0 хувьтай байхаар байна. Эндээс Монгол Улсын төрийн оролцоо 42.2 хувьтай байна гэж үзэж болно. Бид 100 төгрөг олоод 42 төгрөгийг нь буцаагаад төрдөө зарцуулж байна гэсэн үг” хэмээн бичиж байсан. Мөн төрийн албан хаагчдын тоог аваад үзэхэд 2005 оноос хойш долоон жилийн дотор даруй 34.9 хувиар нэмэгдсэн. Гэтэл төрийн албаны үйлчилгээний чанар хүртээмж дээрх хувиар сайжирч чадсан уу гэвэл үгүй. Төрийн оролцоо их байгааг харуулах нэг индекс бол авлига.



“Mongolian Economy” сэтгүүлийн том төрийн тухай тусгай дугаарын хавтасны зураг. 2013 оны 11 сар

Хэдийгээр манай улсын авлигын индекс бага багаар буурч, эдийн засгийн эрх чөлөөгөө нэмэгдүүлсээр байгаа ч төрийн оролцоо их байгаа учраас эдгээр чиглэлээр дорвитой үр дүнд хүрэхгүй байгааг улс төрийнхөн болоод бизнесийнхэн хэлдэг. ▶

## ► Төрийн дэмжлэг, төрийн оролцоо гэдэг үгс “баяртай”

Төрийн бүтэц данхар, хүртээмж, үйлчилгээ нь сул байгааг хаана хаана хүлээн зөвшөөрч буй учраас хэрхэн сайжруулах талаар ярьж эхлэх ёстой байв. Тэгвэл энэ талаар Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж “Том төрөөс ухаалаг төр рүү” гэсэн санаачилга гаргасан. Төрийг цомхон, чадварлаг, хүнд сурталгүй үйлчилдэг, хувийн хэвшил төрийн дарамтгүй ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэх нь санаачилгын гол агуулга.

Тэгвэл тэрбээр өнгөрсөн сарын 19-21-нд Улаанбаатар хотноо болсон “Mongolia Business Summit-2014”-д өндөр ач холбогдол өгч, үг хэлэх үеэрээ цаашид Монголын төр дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдыг дэмжинэ гэдгийг тодорхой хэлсэн юм. Ингэхдээ хэд хэдэн тодорхой санал, зарчмын чанартай асуудлыг дуулгасан. Тухайлбал, Ц.Элбэгдорж “Бидний сонгосон төр хэзээ зөв болох вэ гэвэл нэг талаас хуулиа хэрэгжүүлдэг төр, нөгөө талаас төрөөс хариуцлага шаардаж, бас түүнийг нь хүлээлгэж чаддаг зохион байгуулалттай олон нийт байх юм бол Монголын нийгэм зөв замаар явна. Миний харж байгаагаар зохион байгуулалттай, хамгийн хүчтэй байж болох салбар бол манай хувийн хэвшил юм. Өнөөдрийн хурлыг хувийн хэвшлийн зүгээс санаачилж, төрийн дэмжлэгтэйгээр хийж байгаа нь Монголын хувийн хэвшил зохион байгуулалтад орж ажиллах эхлэл тавигдаж байна гэж харж байна. Манайд өнөөдөр ийм зохион байгуулалт хэрэгтэй байгаа. Би хувьдаа хувийн хэвшлийг байнга дэмжих бодолтой байгаа. Яагаад гэвэл хувийн хэвшил хамгийн бага зардлаар хамгийн оновчтой шийдлийг олж ажилладаг. Тэд хариуцлагатай, хэмнэлттэй, хяналттай байж чаддаг. Харин төр оролцохоор аливаа зүйл үнэтэй тусаж, чанаргүй хийгдэж, улс төржүүлдэг. Төрийн олсон зээл хүртэл нулимстай байна. Тиймээс өнөөдрөөс эхлээд бид төрийн дэмжлэг гэх биш, хувийн хэвшлийн дэмжлэг, төрийн оролцоо гэх биш, хувийн хэвшлийн оролцоо гэж ярьж хэвших хэрэгтэй” гэв. Тэрбээр хувийн хэвшлийг дэмжих төрийн бодлогыг зүгээр ч нэг сэтгэлийн хөөрлөөр эсвэл дан ганц өөрийн бодлоо эхлчихээгүй юм. Хувийн хэвшлийг дэмжих тухай төрийн бодлого гаргах түвшинд ярьж эхэлсэн нь олзуурхууштай. Төрийн оролцооны асуудалд Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, УИХ-ын дарга ҮАБЗ дээр тодорхой бодлого гаргаж, чиглэл өгсөн байна. Харамсалтай нь өнөөдөр төрийн албаны зарим нь энэ талаар юу ч мэдээгүй дуулаагүй юм шиг царайлж байгааг Ерөнхийлөгч буруутгасан. Түүнчлэн Засгийн газрын зүгээс ч гэсэн Эдийн засгийг эрчимжүүлэх 100 хоногийн арга хэмжээг хувийн хэвшлийнхэнтэй хамтарч хийж, тэдний санал санаачилгыг авч байгаа нь шинэ үзэгдэл. Ерөнхийлөгч ч гэсэн үүнийг том дэвшил гэж харж буйгаа хэлсэн.

## Хувийн хэвшлийн оролцоо 60 хувиас багагүй, төрийн оролцоо 40 хувиас ихгүй байна

Мөн түүний илтгэлд дурдагдсан нэгэн шинэ санаа бол цаашид дотоод, гадаадад хувийн хэвшил хувийн хэвшилтэйгээ бизнес ярьдаг зарчимд шилжих тухай байв. “Уул уурхайн баялаг эзэмших гэж байгаа бол төр мөнгөө

оруулна. Хувийн хэвшил санаачилгыг гартаа авч, хэрвээ төр мөнгөгүй байх юм бол саналаа өөр хөрөнгө оруулагчид тавиад үйлдвэрлэлээ эхлүүлээд явдаг байх хэрэгтэй. Ер нь цаашдаа хувийн хэвшлийн оролцоо 60 хувиас багагүй, төрийн оролцоо 40 хувиас ихгүй байна гэсэн зарчим байх ёстой” хэмээн төрийн тэргүүн эрс шийдэмгий хэллээ. Өнгөрсөн хугацаанд төрийн зүгээс томоохон уурхайнуудыг эргэлтэд оруулах гэж ихээхэн хүндрэлтэй учирч буй туршлага ийнхүү төрийн бодлогыг шинэ зарчимд шилжихэд хүргэсэн бололтой. Энэ талаар Ц.Элбэгдорж “Төрийн төлөөлөл яваад очихоор өмнөөс нь улс төр, том бодлого ярьдаг. Гэтэл хоёр бизнесийн хүн уулзахаар бизнесээ л ярина. Бизнесийн хүнээс сайдаас шаардаж байгаа шиг зүйл шаардахгүй. Хувийн хэвшлийнхний хувьд ярьсан бизнес дээр нь төрөөр шийдүүлэх зүйл юу байна. Ямар татварын хөнгөлөлт, хоёр Засгийн газар хооронд ямар хэлэлцээр хийх хэрэгтэй талаар төрд ханддаг. Түүнд нь төр тусалдаг. Ийм зарчим руу орох юм” гэв.

“Ухаалаг төр гэдэг бол төр хийх ёстой зүйлээ хийж, байх ёстой байрандаа байх” гэж Ерөнхийлөгч тодорхойллоо. Тэгэхээр төрийг байранд нь аваачиж тавих асуудалд зөвхөн хувийн хэвшлийн идэвх санаачилгаас гадна олон нийт, хэвлэл мэдээллийн байгууллагынхны үүрэг оролцоо их. Өдгөө төрийн хүнд суртал, бүтэлгүй ажиллагаанаас болж Монголын хөрөнгө оруулалт, бизнесийн салбарт учирсан хохирол мундахгүй. Тиймээс нийгмээрээ том төрөөс залхаж буй юм.

Тэртээ 1980-аад оны сүүлч, ерээд оны эхээр өргүй хоосноос ганзагын наймаанд бэлчиж эхэлсэн Монголын хувийн хэвшил өдгөө үндэсний том хөрөнгөтнүүдийг төрүүлж чадсан. Түүнчлэн Монгол Улсын ДНБ-ий 80 хувийг дангаараа үйлдвэрлэж ирсэн гавьяатай. Өнгөрсөн хугацаанд Монголд 2-3 удаагийн эдийн засгийн хямрал болоход хувийн хэвшил ачааны хүндийг нуруундаа үүрч гарсан. Цаашид хэзээ ч айлчилж болох хямралд хувийн хэвшил байнга зүтгэх хүч, тулах багана болсон хэвээр байх учраас ийнхүү Монгол Улсын төрийн тэргүүн хувийн хэвшилд чөдөр тушаа болдог том төрийн оролцоог хязгаарлаж, бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагчдыг дэмжихээ 22 орны 200 гаруй хөрөнгө оруулагч тухлан саатсан, нийтдээ 400 гаруй оролцогчтой “Монголын бизнесийн Дээд хэмжээний чуулган” уриалсан юм. Түүний бизнесийнхэнд итгэж найдах бодол тууштай байж, хөрөнгө оруулагчдад хандсан зоримог үгс нь үйлдэл болно гэдэгт хувийн хэвшлийнхэн хүлээх биш, хүч хавсран орох хэрэгтэй боллоо.

Төрийн оролцоо их байх нь үргүй зардал ихэсч, иргэндээ наалдацгүй эдийн засгийн өсөлтийг бий болгож, хүний эрх, эрх чөлөөг боомилж, хүнд суртал газар авч, авлига цэцэглэдэг гэдгийг монголчууд хангалттай харлаа. Тиймээс төрийн тэргүүний үг бас нэгэн шинэ санаачилга, эр зориг, шинэ хандлага байлаа.

Тийм болохоор “Mongolian Economy” сэтгүүл энэхүү нийгэмд сайн сайхан, хөгжил дэвшлийг авчрах сайн үйл бүтэхийг ерөөж уг сэдвийг шинэ дугаарын онцлох нийтлэлээ болгоод зогсоогүй сэтгүүлийнхээ эхний нүүрийг ч шинэ санааг зурагласан шог зургаар өнгөллөө. Манай сэтгүүл өмнө нь ч том төрд шүүмжлэлтэй хандаж ирсэн болохоор төрийг байранд нь тавьж, баялаг бүтээгчдийн санал санаачилга, үйл хэрэгт дөрөөлж хөгжих төрийн тэргүүний дэвшүүлсэн шинэ зорилтыг бодлогоо болгон ажиллах болно. ■

## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

## САЛХИ ЭРГЭЛЭЭ

## Б.БАЯРТОГТОХ

Эдийн засгийн унасан үзүүлэлтээ өөд татах нэг хувилбар нь гадаадын хөрөнгө оруулалтыг оруулах явдал. Тэгвэл энэхүү хүслийг өвөртөлсөн “Монголын бизнесийн Дээд хэмжээний уулзалт-2014” Улаанбаатар хотноо өнгөрсөн сарын 19-21-нд боллоо. Эдийн засгийг эрчимжүүлэх 100 хоногийн хүрээнд зохион байгуулсан уг арга хэмжээ нь анх удаа хувийн хэвшлийн санаачилгаар болж, гадаад, дотоодын 400 гаруй төлөөлөгч “Их тэнгэр”-т чуулсан. Хурлын үеэр уул уурхай, дэд бүтэц, санхүү, аялал жуулчлал гэх мэт салбарын 18 төслийг зочдод танилцуулав. Ерөнхийлөгч, Ерөнхий сайдаас гадна уул уурхай, эрчим хүч зэрэг холбогдох салбарын сайд нар хуралд өндөр ач холбогдож өгч оролцож, өөрсдийн хариуцсан салбарын бодлогын талаар мэдээлэл өгч, хөрөнгө оруулагчдын сонирхсон асуултад хариулсан.

“Оюутолгой” төслийн тухайд “Эрдэнэс Оюутолгой” компанийн гүйцэтгэх захирал Да.Ганболд “Оюутолгой төсөл хөдлөх үү, цааш амьдрах уу гэсэн асуудал огт байж болохгүй. Онгоцоор ярих юм бол Оюутолгой хөөрөөд очих ёстой газрын зүг ниссэн. Энэ оны эцэс гэхэд нэг сая тонн баяжмал арилжаалах тооцоотой ажиллаж байгаа. Гүний уурхай хуваарь ёсоор 2016 он гэхэд бүтээгдэхүүнээ зах зээлд нийлүүлнэ” хэмээн хөрөнгө оруулагчдын дунд төдийгүй нийгэмд үүсээд байсан эргэлзээг үргээсэн юм. Харин “Эрдэнэс Тавантолгой”-н гүйцэтгэх захирал Я.Батсуурь хөрөнгө оруулалт шаардлагатай байгаа төслүүд болон Тавантолгойн ордын нөөц боломжийн талаар өгүүлсэн. ▶



Фотог Б.Бямба-Очир

“Монголын бизнесийн Дээд хэмжээний уулзалт-2014”-д ирсэн гадаадын зочид, төлөөлөгчдийн 60 хувь нь анх удаа Монголд хөл тавьжээ.

▶ Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг танхимын гишүүдтэйгээ Дээд хэмжээний уулзалтад ихэд ач холбогдож өгч, хувийн хэвшилтэйгээ нэг завинд “суусан”. Өөрөөр хэлбэл, нэг чиг зорилгын өмнө төр, хувийн хэвшил байр сууриа нэгтгэснээрээ энэ удаагийн чуулган нэлээд онцлогтой болов. Энэ нь олон улсын хөрөнгө оруулагчдад итгэл төрүүлсэн байж мэднэ. “Монголын эдийн засгийн форум” ТББ, СЕО клуб, Монголын бизнесийн зөвлөл зэрэг хувийн хэвшлийн санаачилга, Засгийн газрын дэмжлэгтэйгээр болсон “Монголын бизнесийн Дээд хэмжээний уулзалт” хурлын шинэ жишиг тогтоох талаар зохион байгуулагч, модратор “Нова Терра” компанийн захирал Б.Бямбасайхан онцолсон.

Монголын хөрөнгө оруулалтын шинэ орчинд ирж ажиллах, тэр тусмаа хөрөнгө оруулагчдын хувьд хөрөнгө өсгөх боломжтойг энэ удаагийн чуулга уулзалт илтгэсэн. Ерөнхий сайд “Эдийн засгийг эрчимжүүлэх 100 хоногийн хүрээнд Засгийн газар бизнес эрхлэх орчныг тогтвортой, таатай болгох, бизнес эрхлэгч, баялаг бүтээгчдэд учирч буй саад бэрхшээл, дарамтыг зогсоохын төлөө ажиллаж байна.

Монголд хөрөнгө оруулалт шаардлагатай байгаа томоохон 18 төсөл бий. Эдгээр төслийн нийт хөрөнгө оруулалтын хэмжээ 15 тэрбум ам.доллартай тэнцэж буй. Ийм хэмжээний хөрөнгийг төсвөөс нэг дор санхүүжүүлэх боломжгүй. Тиймээс хөрөнгө оруулагчдад найдахаас өөр гарц харагдахгүй байгаа юм. Монгол Улсад ойрын 15 жилийн хугацааны бүтээн байгуулалтад нийтдээ 60 гаруй тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт шаардлагатай гэсэн Эдийн засгийн хөгжлийн яамны судалгаа бий. Тэгвэл ДНБ-ий хэмжээг тав дахин нугалсан дээрх хэмжээний хөрөнгийн эрэлд Засгийн газар аль хэдийнэ мордсон.

Хөрөнгө оруулагчдын итгэлийг дахин сэргээх амаргүй ажил. Гэхдээ Монгол Улс хөрөнгө оруулагчдын анхаарлын төвд байгаа Гадаадын хөрөнгө оруулалтын газрын дарга С.Жавхланбаатар хэллээ. Тэрбээр “Хөрөнгө оруулагчдад тодорхой

хугацаа шаардлагатай. Монгол Улсад орж ирж буй хөрөнгө оруулагчдын бүтэц өөрчлөгдөж байна. Өөрөөр хэлбэл, хөрөнгө оруулалт төрөлжиж байна. Өмнө нь зөвхөн уул уурхайн салбарт хөрөнгө оруулагчид хошуурдаг байсан бол одоо бусад салбар тэдний анхаарлыг татах болсон” гэв. Монголын эдийн засагт “шинэ мөнгө” ус агаар мэт хэрэгтэй байгаа. Энэ нь шинэ ажлын байр бий болгож, эдийн засгийг тэлж байдаг хөрөнгө оруулалт.

“ Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг танхимын гишүүдтэйгээ Дээд хэмжээний уулзалтад өндөр ач холбогдож өгч, хувийн хэвшилтэйгээ нэг завинд “суусан”. Өөрөөр хэлбэл, нэг чиг зорилгын өмнө төр, хувийн хэвшил байр сууриа нэгтгэснээрээ энэ удаагийн чуулган нэлээд онцлогтой болов. ”

Хөгжлийн эдийн засгийн судалгаагаараа дэлхийд нэлээд нэрд гарч буй Даниел Алтман гэх залуу энэ онд “Where to invest” хэмээх нэртэй дэлхийн хөрөнгө оруулалтын халуун цэгүүдийн тухай судалгаа хийж, тайлан гаргасныг тус хурлын үеэр Ерөнхийлөгчийн зөвлөх П.Цагаан танилцуулсан. Судалгааны жагсаалтад Монгол Улс эхний аравт багтжээ. Энэ нь хөрөнгө оруулагчид Монголд итгэж, зөв газраа хөрөнгө оруулах тохиромжтой цаг болсныг тэрбээр учирласан юм.

Манай улсын ДНБ-ий хэмжээ сүүлийн хоёр жилийн дотор арав дахин өссөн. Нэг тэрбумаас арван тэрбум болтлоо богино хугацаанд

тэлсэн эдийн засагтай улс дэлхийд цөөн аж. Ирэх 20 жилийн хугацаанд эдийн засаг тогтвортой хоёр оронтой тоогоор өссөн тохиолдолд 100 тэрбум ам.долларын эдийн засагт шилжих юм. Ерөнхийлөгч, Ерөнхий сайд болон Засгийн газрын сайдууд хувийн хэвшлээ сонсож хамтран ажиллахад бэлэн байгаагаа Дээд хэмжээний уулзалтын үеэр илэрхийлсэн.

Бизнесийн дээд хэмжээний уулзалтын үеэр сүүлийн 20 жилийн турш яригдсан V цахилгаан станцын 1.3 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалттай 450 МВт-ын хүчин чадалтай станцын барих, ашиглах, шилжүүлэх гэрээнд талууд гарын үсэг зурсан томоохон үйл явдал тохиолоо.

Хөрөнгө оруулагчдын зүгээс ирэх оны зургадугаар сараас бүтээн байгуулалтын ажил эхэлнэ хэмээн мэдэгдсэн. Харин үүнээс өмнө бэлтгэл ажлаа хангах үүднээс зарим гэрээг үзэглэх аж. Төслийг хэрэгжүүлэхэд 640 гаруй ажлын байр шинээр бий болно гэсэн урьдчилсан тоцоо гарчээ. Хөрөнгө оруулагчдын анхааралд өртсөн дараагийн төсөл нь Тавантолгойн цахилгаан станц. Монгол Улсын мега төслүүдийн нэг болох тус төслийн хувьд урьдчилсан шалгаруулалтад багтсан дөрвөн компанид энэ сард арилжааны саналаа хүргүүлэх юм. Ингэснээр Тавантолгойн цахилгаан станцад талууд тохиролцож, эцсийн байдлаар гэрээнд гарын үсэг зурах бололтой. Тавантолгойн цахилгаан станцыг барихад урьдчилсан байдлаар нэг тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт шаардлагатай.

Хөрөнгө оруулагчдад Монголын бизнесийн орчинг бодитоор харуулах үүднээс тус чуулганы гурван дахь өдөр Монголд хэрэгжиж буй томоохон төсөл болох Оюутолгой, Ухаа худаг, АПУ, “Говь” ХК, МАК-ийн цементийн үйлдвэр газар дээр нь аваачин танилцуулсан.

“Бизнесийн Дээд хэмжээний уулзалт” нь Монголын бизнес, эдийн засгийн нөхцөл байдлыг хөрөнгө оруулагч нарт ойлгуулах, Монгол дахь бизнесийн шинэ боломжуудыг нээх, хөрөнгө оруулагчдын итгэлийг олоход том түлхэц болохоор байв. Цаашид энэхүү арга хэмжээг жил бүр Улаанбаатар хотноо зохион байгуулах юм. ■

ФОТО БУЛАН



“Монголын бизнесийн Дээд хэмжээний чуулга-2014”-д 22 орны 200 гаруй зочид төлөөлөгчид оролцож, Монголын бизнес, хөрөнгө оруулалтын орчны талаар хэлэлцлээ.





Фотог Б.Бямба-Очир

## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

# ГЕРМАН ЧАНАР МОНГОЛД



Германы компаниуд Монголд үзэсгэлэн гаргалаа

## Б.БАЯР

“Герман-Монголын бизнесийн өдрүүд-2014” чуулга уулзалт өнгөрсөн сарын 17-18-нд Улаанбаатар хотноо боллоо. Гурав дахь жилтэйгээ золгож буй чуулга уулзалт “Германд үйлдвэрлэв” уриан дор болж, хоёр өдрийн турш холын Германыг монголчуудад “гайхууллаа”. Герман гэхээр хамгийн түрүүнд “чанар” гэсэн ойлголт толгойд харван орж ирдэг. Энэ нь тус улсыг төсөөлөх хангалттай үндэслэл мөн. Тэгвэл тэд Монголыг ирээдүйтэй шинэ зах зээл хэмээн харж байна.

Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны нийгэмлэг, Герман-Монголын Бизнес эрхлэгчдийн холбоо хамтран зохион байгуулсан энэ жилийн чуулга уулзалт урьд жилүүдийнхээс илүү өргөн цар хүрээг хамарсан гэж хэлж болно. Уулзалт Монголын хөрөнгө оруулалтын орчинд үүсээд буй “уур амьсгал”-ыг зөөллөв. Эрчим хүч, дэд бүтэц, боловсруулах үйлдвэр, компанийн менежмент, бизнесийн үйлчилгээний чиглэлээр хамтран ажиллахад тэд хэзээд бэлхэн гэсэн. Мөн уул уурхайн бус салбарт ч хамтран хүчээ нэгтгэхэд үнэнч түнш байхаа үйлдлээрээ илэрхийлж байгаа.

Монгол Улс, ХБНГУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 40 жилийн ой энэ онд тохиож буй. Хоёр улсын найрамдалт харилцааны түүхт ойн хүрээнд болж буй томоохон арга хэмжээний нэг нь “Герман-Монголын бизнесийн өдрүүд-2014” байлаа. Германы олон улсын хамтын ажиллагааны Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачилга хөтөлбөрийн захирал Штефан Ханселман “Герман уул уурхайн орон биш. Гэхдээ дэд бүтэц, усны менежмент, сэргээгдэх эрчим хүч, мэдээлэл технологийн

салбарт дэлхийд тэргүүлэгч гэж хэлж болно. Тиймээс эдгээр салбаруудад Монгол Улстай хамтран ажиллах сонирхол ихээхэн байгаа. Тухайлбал, танай УИХ-аас Төрөөс баримтлах Ногоон хөгжлийн үзэл баримтлалыг баталсантай холбоотойгоор Герман Улсын Засгийн газар сэргээгдэх эрчим хүчний салбарт болон ногоон эдийн засгийг хөгжүүлэх чиглэлд хамтран ажиллах боломжтой” гэв.

Герман БНХАУ-ын дараа жагсах дэлхийн хэмжээний экспортлогч төдийгүй үйлдвэрлэгч. Тиймээс Монгол Улстай гуравдагч хөршийн түвшинд хамтран ажиллах боломжтой эдийн засгийн хүчирхэг гүрэн. Бидэнд тэднээс суралцах зүйл бишгүй бий. Хамгийн наад зах нь цаг баримтлах соёлыг тэднээс “хуулан” авч, бусдад үлгэр дуурайлал болох боломжтой бус уу. Бизнесийн алтан зарчмын нэг нь цаг төлөвлөлт.

Чуулга уулзалтын хүрээнд хоёр өдрийн турш Германы компаниуд үзэсгэлэн гаргасан. Тус үзэсгэлэнд оролцсон “GLEOS AG” компанийн гүйцэтгэх захирал Герхард Вакенхүт “Монголын зах зээл эрсдэлтэй байгаа үед бид бизнесээ эхэлж байна. Гэхдээ хэрэглэгчид чанартай бараа, бүтээгдэхүүнээр үйлчлүүлэх ёстой. Монгол Улс цөөхөн хүн амтай учраас эрсдэлээс хурдан гарах боломжтой. Тиймээс өнөөгийн хүндрэлд төдийлэн санаа зовохгүй байна. Эргээд эдийн засаг өснө гэдэгт хүн болгон итгэлтэй байгаа” хэмээсэн.

Герман улсаас манай импортолж буй бараа бүтээгдэхүүний дийлэнх хувийг тоног төхөөрөмж, суудлын автомашин, агаарын тээврийн хэрэгсэлийн сэлбэг, эд анги эзэлж байна. Харин манай улсаас гол төлөв малын гаралтай түүхий эд болон газрын ховор элементийг Германд экспортолжээ. Германы бараа, бүтээгдэхүүн чанартай тусмаа үнэтэй байдаг. Үнийн дүнд чанараас гадна логистикийн хүндрэл, гаалийн өндөр татвар ч нөлөөлдөг байна.

Монгол-Германы хамтын ажиллагаа эхэлснээс хойш 20 жилийн хугацаанд Германы Засгийн газар, олон талт байгууллагуудын хүрээнд олгосон хөгжлийн санхүүжилтүүд нийтдээ 450 сая орчим евро болсон байна. Өнгөрсөн онд хоёр улсын нийт худалдааны эргэлт 270.6 сая ам.долларт хүрч, өрнүүн хамтын ажиллагаа цэцэглэн хөгжиж байна. Одоогоор Германы 300 орчим компани Монголд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа аж. Герман чанар Монголын зах зээлд алхам алхмаар ойртсоор. ■

## ТОМИЛОЛТ

# МОНГОЛЫГ МӨНГӨТЭЙ БОЛГОХ “АЛТАНБУЛАГ”-ИЙН ЧӨЛӨӨТ БҮС



Фотог Т.Чимгээ

“Алтанбулаг” худалдааны чөлөөт бүс байнгын үйл ажиллагаатай болсноор 1000 гаруй км замыг туулдаг байсан бараа бүтээгдэхүүн ердөө 300 км зам туулна

## С.АЗ

Хэдхэн сарын өмнө тал газар байсан энд засмал зам тавьж, асруудыг эгнүүлэн барьжээ. Уртаас урт машины цуваа “Алтанбулаг” худалдааны чөлөөт бүсэд үүсч, худалдаа наймаа эрхлэх гэсэн хүмүүсийн хөлд дарагдаж. Манай улс худалдаа эдийн засгийн чөлөөт бүс байгуулна гэж ярьсаар 10 гаруй жил болсон ч өнөөдөр /зургадугаар сарын 22-нд нээлтээ хийсэн/ ажил хэрэг болсон нь энэ. Ингэснээр Монгол, ОХУ-ын иргэд чөлөөт бүсэд чөлөөтэй зорчихоор боллоо. Эртний уламжлалт худалдааны “Наймаачин” хотын

хуурай замын боомт газрыг түшиглэн байгуулсан “Алтанбулаг” худалдааны чөлөөт бүсээр дамжих үндэстэн дамнасан бараа таваар, санхүүгийн урсгал нь Монгол, БНХАУ, ОХУ гурван улсын эдийн засгийн хамтын ажиллагааны коридор, Монгол Улсын хөгжлийн шинэ гарц болох юм.

“Алтанбулаг” чөлөөт бүс татваргүй орчин. Энэ бол давуу тал. Одоо хамгийн гол нь мөнгө санхүүгийн урсгалыг бий болгох нь чухал аж. Манайх чөлөөт бүс байгуулна гэснээс хойш дорвитой ажил хийгээгүй явж ирсэн учраас хоёр хөршийн бизнес эрхлэгчид, худалдан авагчид

итгээгүйгээс болсон уу Оросын талаас хүн олноор ирээгүй. ОХУ, БНСУ, БНХАУ-ын цөөн бизнесмэн л чөлөөт бүсийн нээлтэд иржээ. Харин Улаанбаатараас монгол иргэд арилжаа хийхээр олноор очиж. Үзэсгэлэн худалдааны нэг павилоныг өдрийн 100.000, найм хоногт нийтдээ 800 мянган төгрөгөөр түрээсэлжээ. УИХ-ын гишүүн Ц.Цолмон чөлөөт бүсийн нээлтийн үеэр “Монгол, ОХУ хоёрын хоорондын худалдаа хамтын ажиллагаанаас гадна өмнөд хөршийн олон нэр төрлийн бараа чөлөөт бүсээр дамжин худалдаалагдах байх. Эхний ээлжинд бараа худалдааны замаар ▶

▶ явна. Цаашид үйлдвэрлэл хөгжөөсэй. Учир нь, чөлөөт бүсэд худалдаа үйлдвэр явуулах түүхий эд болон бусад бүтээгдэхүүн цугларна. Үүнийг ашиглаад олон төрлийн үйлдвэрлэл хөгжүүлэх боломжтой. Шинэ ажил эхлэхэд олон бэрхшээл бий. Худалдан авах тал нь мэдээлэл муутай байна. Үүнийг хоёр улсын хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон талаас нь сурталчилж, мэдээлэл хүргэх нь зүйтэй” гэв.

Чөлөөт бүсэд гадаадын иргэд визгүй зорчиж байсан бол монголчуудыг цагаан хуудсаар нэвтрүүлж байв. Олон улсын туршлагаас харахад, чөлөөт бүсэд баримтлах гол бодлого нь нэн түрүүнд иргэд чөлөөтэй зорчих ёстой байдаг аж. Өөрөөр хэлбэл, визгүй гэсэн үг. Хоёрдугаарт, гадаадын хөрөнгө оруулалт орж ирэхэд таатай нөхцөлийг бүрдүүлж, хүнд суртал, чирэгдэлгүй үйлчлэх орчин бүрдүүлэх гэнэ. Манайх энэ зарчмаар явахаар төлөвлөж, ажлаа эхлүүлсэн байна. Чөлөөт бүсэд амьдрах монголчууд “Алтанбулаг” чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албанаас оршин суух зөвшөөрөл авах ёстой. Хятад, БНСУ зэрэг Зүүн өмнөд Азийн орны иргэдэд тухайн улс дахь Монголын ЭСЯ-нд хандан, “Алтанбулаг” худалдааны чөлөөт бүсэд зорчих транзит виз авах боломжтой. Чөлөөт бүс нээгдсэнтэй

холбогдуулан Алтанбулаг, Хиагт боомтыг долдугаар сарын 1-нээс 24 цагаар ажиллуулах юм.

Энэ талаар “Алтанбулаг” чөлөөт бүсийн Захирагчийн албаны дарга Ч.Чимэдцэрэн “Алтанбулаг чөлөөт бүс бизнес эрхлэгчдэд маш том боломжууд бий болгож байна. Дэлхий нийтийн туршлагаас харахад, чөлөөт бүсэд бүхий л төрлийн үйл ажиллагаа явуулахыг хүлээн зөвшөөрдөг юм билээ. Энэ утгаараа чөлөөт бүс өргөн хүрээнд хөгжих боломжтой. Гадаад дотоодын хөрөнгө оруулагчдыг татахад энэ таатай орчин нь нөлөөлдөг. Ирэх онд ОХУ, БНХАУ-ын хооронд 100 тэрбум ам.долларын худалдаа арилжааны стратегийн түншлэлийн гэрээ хийгдэнэ. Үүнээс ганцхан тэрбум ам.долларыг худалдааны чөлөөт бүсээр дамжуулж үйл ажиллагааг нь хэрэгжүүлбэл бид дотоод зах зээлдээ 100-200 сая ам.доллартай тэнцэх хэмжээний худалдааны ашиг хүртэх боломжтой. Энэ бизнесийн үйл ажиллагааг жижиглэнгийн худалдаачдаас эхлээд томоохон аж ахуйн нэгжүүд хэрэгжүүлэх өргөн боломж бүрдэнэ” гэв.

ОХУ-ын иргэд тэр дундаа Буриад улсын ДНБ-ий 70-80 хувь нь БНХАУ-ын бараа бүтээгдэхүүнээр хангагддаг гэсэн тооцоо байдаг аж. Уг бараа бүтээгдэхүүн БНХАУ, Манжуур, ОХУ

гэсэн маршруттайгаар Монголыг тойрон эзэндээ хүрдэг. Харин одоо “Алтанбулаг” худалдааны чөлөөт бүс байнгын үйл ажиллагаатай болсноор 1000 гаруй км замыг туулдаг байсан бараа бүтээгдэхүүн, мөнгөний урсгал Монголын нутаг дэвсгэрээр ердөө 300 км зам туулан эзэндээ очих нь.

Чөлөөт бүсэд өдгөө барилгын материал болон авто худалдааны төв байгуулж эхэлжээ. Бусад худалдааны төвийг долоо, наймдугаар сараас барьж эхлэх юм байна. Мөдхөн ашиглалтад ороход бэлэн болсон хоёр давхар худалдааны төвийн 24-72 ам.метр хэмжээтэй 80 гаруй лангууг түрээслэх аж. Чөлөөт бүсийн нээлтэд зориулсан үзэсгэлэн худалдаа энэ сарын 29-нд дуусах бол худалдаа, бизнесийн үйл ажиллагаа есдүгээр сарын 22 хүртэл үргэлжилнэ. Энэ хугацаанд гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татаж чадвал үйл ажиллагаагаа байнгын болгож, цаашид 24 цагаар ажиллахаар төлөвлөжээ. Энэ талаар УИХ-ын гишүн С.Баярцогт “Энэ ажил монголчууд төдийгүй ОХУ, БНХАУ-ын бизнес эрхлэгчдийн хувьд нүдээ олсон зүйл боллоо. УИХ-аар Чөлөөт бүсийн тухай хуулийн төслийг хэлэлцэж байгаа. Цаашид олон асуудлыг шийдвэрлэх болно. Энэ үйл ажиллагаа гурван улсын эдийн засгийн ▶



Эдийн засгийн чөлөөт бүс хөрөнгө оруулалт татахад нөлөөтэй

► томоохон хамтын ажиллагаа болж чадна гэдэгт итгэлтэй байна” гэлээ.

“Алтанбулаг” чөлөөт бүсийн хөгжилтэй холбоотойгоор Сэлэнгэ аймаг маш их өөрчлөгдөнө гэж тус аймгийн удирдлагууд үзэж буй аж. Энд гаалийн болон НӨАТ төлөхгүйгээр бараа бүтээгдэхүүнээ арилжих боломжтой. Тиймээс иргэддээ таатай нөхцөл бүрдүүлж, чөлөөт бүстэй уялдуулж, Алтанбулаг хотыг хөгжүүлэх, цаашлаад боомт болгох чиглэлд анхаарч ажиллахаар болжээ. Өмнө нь чөлөөт бүсэд аж ахуйн нэгжүүд га, га-гаар нь газар эзэмшдэг байсан. Харин одоо энэ хэмжээг 200 ам.метр болгон өөрчилжээ. Өөрөөр хэлбэл, нэг аж ахуйн нэгжид 10 мянган ам.метр газар байсан бол одоо түүнийг 50 компани эзэмшдэг болно. Энэ нь бизнес эрхлэгчдэд таатай орчин бүрдүүлж, үйл ажиллагаагаа саадгүй явуулахад томоохон түлхэц болох аж. “Алтанбулаг” чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны бодлого ч энэ чиглэл рүү явж байгаа гэсэн. Гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд тухайн газрыг ашиглах эрхтэй гэнэ.

ОХУ-ын зүгээс чөлөөт бүсээ байнгын, “Алтанбулаг” боомтыг 24 цагийн ажиллагаатай болгох санал тавьжээ. “Чингис” хурдны зам төсөл чөлөөт бүсээс эхэлж, зам тавих аж. Энэ талаар Эдийн засгийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Шинэбаатар “Торгоны замын нэг салааг Монголоор дамжуулж хөгжүүлж байсан түүх байдаг юм билээ. “Алтанбулаг” чөлөөт бүсийн нээлт энэ боломжийг цааш үргэлжлүүлж байна. Үүнтэй зэрэгцээд Цагааннуурын чөлөөт бүс бас яригдаж байгаа” гэв.

Манай улс хоёр хөрштэйгээ худалдаа наймаа хийх, Монголоор дамжих мөнгөн урсгалыг бий болгох ажлын эхний алхмаа хийлээ. Одоо төр засгийн бодлого хааш чиглэхээс энэ ажил ихээхэн шалтгаална. Олон жил ярьсан, хүлээгдэж байсан ажлынхаа гогцоог Засгийн газар “Эдийн засгийг идэвхижүүлэх 100 хоног”-ийн хүрээнд тайллаа. Цаашид үйл ажиллагааг нь тасалдуулалгүй, зөв бодлого барьж ажиллах чиг үүрэг Монголын Засгийн газар тэр дундаа Эдийн засгийн хөгжлийн яамныханд ногдлоо. ■

## ЭРЧИМ ХҮЧНИЙ ШИНЭ ЭХ ҮҮСВЭР БАРИАНЫ ЗҮГ



### Б.ЭРДЭНЭ

Эдийн засгийг эрчимжүүлэх 100 хоногийн хүрээнд 450 МВт-ын хүчин чадал бүхий “V цахилгаан станц”-ын Концессын гэрээг үзэглэлээ. Нийслэлийн өсөн нэмэгдэж буй дулаан, цахилгааны хэрэгцээг хангах төсөл ийн олон жилийн дараа хэрэгжихээр боллоо. Францын GDF Suez, Японы Sojitz, Өмнөд Солонгосын Posco Energy” Монголын “Newcom” группын байгуулсан Монгол Улсад бүртгэлтэй “Фифт Комбайнд Хийт Энд Пауэр Плант” компани “V цахилгаан станц”-ын концесс олгох сонгон шалгаруулалтад сонгогдож, эрх авлаа.

Концесс эзэмшигч тус компани нэг жилийн хугацаанд хөрөнгө оруулалтаа шийдвэрлэн, Цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ, Газар ашиглах гэрээ, Ус ашиглах гэрээг Монгол Улсын төрийн захиргааны холбогдох байгууллагуудтай тус тус хийснээр концессын гэрээ хүчин төгөлдөр болж, үүний дараа станцын барилга угсралтын ажил эхэлнэ. Гэрээг төр-хувийн хэвшлийн түншлэл буюу Концессын БАРИХ-АШИГЛАХ-ШИЛЖҮҮЛЭХ нөхцөлөөр байгуулж буй бөгөөд концесс эзэмшигч нь “V цахилгаан станц”-ыг дөрвөн жилийн хугацаанд барьж, 25 жил ашигласны дараа Монгол Улсын төрд үнэ төлбөргүй шилжүүлэх үүрэг хүлээж буй.

Станцын хүчин чадлын хувьд цахилгаан 450 МВт, дулаан 587 МВт

байна. Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө хамгийн бага CFB /circulating fluidized bed/ технологи ашиглах юм. Ингэснээр гэр хорооллын хүн амыг нэгдсэн халаалт бүхий орон сууцны хороололд шилжүүлэх суурьшуулах боломж бүрдэх аж. Станцын усны хэрэглээ нь III цахилгаан станцтай харьцуулахад зургаа дахин бага байх юм. Төслийг хэрэгжүүлэхэд нийтдээ 650 ажлын байр шинээр бий болох урьдчилсан тооцоо гарчээ. Станц ашиглалтад орсноор 300 орчим монгол ажилтан тогтмол ажилтай байх юм.

Төслийн нийт өртөг нь 1.2 тэрбум ам.доллар бөгөөд тус зардлыг “Фифт Комбайнд Хийт Энд Пауэр Плант” компани гаргах юм. Одоогийн байдлаар албан бус, харилцан ойлголцлын хүрээнд 950 сая ам.долларыг босгоод байгаа аж. Өөрөөр хэлбэл, шаардлагатай хөрөнгийн 80-85 хувийг зээлийн эх үүсвэрээр бүрдсэн. V цахилгаан станцын бүтээн байгуулалтын ажил ирэх оны долдугаар сарын 1-нээс эхэлж, 2017 онд ашиглалтад оруулахаар төлөвлөж байгаа юм. V цахилгаан станц нь 30 жилийн дараа баригдаж буй шинэ технологи. III, IV цахилгаан станцуудтай харьцуулахад бараг гурав, дөрөв дэх үеийн шинэ технологи нэвтэрч байгаа учраас ашиглаж байгаа нүүрсний зарцуулалт нь харьцангуй бага байх нь. Гол давуу тал нь дулаан цахилгааны хамтарсан, хосолсон цахилгаан станц. ■



Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн урилгаар Бүгд Найрамдах Латви улсын Ерөнхийлөгч Андрис Берзинш айлчиллаа

## АЙЛЧЛАЛ

# ЗОЧДЫН ХӨЛД ДАРАГДСАН САР

### Б.БАЯРТОГТОХ

**М**онгол Улс дэлхий нийтийн анхаарлын төвд байна. Ингээд өнгөрсөн сард болсон томоохон айлчлалын багц мэдээг сэтгүүлийнхээ уншигч танд хүргэж байна.

**1.** Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн урилгаар Бүгд Найрамдах Латви Улсын Ерөнхийлөгч Андрис Берзинш өнгөрсөн сарын 11-13-нд Монгол Улсад албан ёсны айлчлал хийлээ. Энэхүү айлчлал нь Латви Улсын Ерөнхийлөгчийн түвшинд Монгол Улсад хийж буй анхны айлчлал. Европын холбоо болон НАТО-гийн гишүүн, эдийн засгийн хямралыг үлгэр жишээ даван туулж, эдийн засгаа эрчимжтэй хөгжүүлж буй Латви улстай хоёр талын харилцааг идэвхжүүлэх талаар ярилцаж, цаашдын хамтын

ажиллагааны чиглэлийг тодорхойлоход энэхүү айлчлал чухал үүрэг гүйцэтгэжээ.

Тус улс нь Европын Холбооны Зөвлөлийг ирэх онд даргалах юм. Айлчлалын үеэр дипломат болон албан паспорт эзэмшигчдийг визийн шаардлагаас чөлөөлөх тухай хэлэлцээр байгуулж, гарын үсэг зурлаа. Ингэснээр 180 хоногийн хугацаанд 90 хүртэлх хоног харилцан визгүй зорчих боломжтой болж байна. Монгол Улс шинээр тусгаар тогтносон Бүгд Найрамдах Латви улстай 1991 оны аравдугаар сарын 15-нд дипломат харилцаа тогтоожээ. Тус улсын Ерөнхийлөгч Андрис Берзинш Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийг тааламжтай цагтаа Бүгд Найрамдах Латви улсад айлчлахыг урьсан юм. ▶

2. БНХАУ-ын Гадаад хэргийн сайд Ван И Гадаад харилцааны сайд Л.Болдын урилгаар өнгөрсөн сарын 24-26-нд Монгол Улсад албан ёсны айлчлал хийлээ. Энэ нь Монгол Улсын Гадаад харилцааны сайдын энэ оны нэгдүгээр сард Хятадад хийсэн айлчлалын хариу айлчлал аж. Энэ онд хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 65 жилийн ой, Найрсаг хамтын ажиллагааны гэрээг шинэчилсний 20 жилийн ой тохиож буй. Тиймээс 2014 оны хоёр тал “Найрсаг солилцооны жил” болгон зарласан. Айлчлалын гол зорилго нь ойрын хугацаанд БНХАУ-ын дарга Си Зиньпинийн манай улсад хийх төрийн айлчлалын бэлтгэлийг хангах, Гадаад харилцааны яамд хоорондын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн хөгжүүлэх, хоёр талын харилцааны болон бусад харилцан сонирхсон асуудлаар мэдээлэл, санал солилцож, нэгдмэл ойлголтод хүрэхэд оршжээ.




Монгол Улсын зүгээс арьс шир боловсруулах, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх талаар Турк улсын туршлагаас судлахын зэрэгцээ хамтран ажиллах хүсэлтэй байгааг илэрхийлсэн. Мөн Туркийн хөрөнгө оруулалтыг орон сууц, дэд бүтэц, эрчим хүч, аялал жуулчлал зэрэг салбарт түлхүү оруулах сонирхолтой байгаагаа энэ үеэр уламжилсан. Нэг зүйлийг дуулгахад, Турк улс нь АСЕАН-д гишүүнээр элсэх хэтийн төлөвлөгөөтэй байгаа аж.

3. Бүгд Найрамдах Турк улсын Үндэсний их хурлын дарга Жемил Чичек УИХ-ын дарга З.Энхболдын урилгаар зургадугаар сарын 23-26-нд манай улсад албан ёсны айлчлал хийлээ. Энэхүү айлчлал нь Монгол, Турк хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 45 жилийн ойн босгон дээр тохиосон юм. Энэхүү түүхэн өдөр нь зургадугаар сарын 24 аж. Хоёр улсын иргэд 30 хоногийн хугацаатай харилцан визгүй зорчиж байгааг тэмдэглэе. Туркийн үндэсний агаарын тээвэрлэгч “Turkish Airlines” компани долоо хоногт гурван удаа 500 зорчигчийн хязгаарлалтайгаар шууд нислэг үйлдэж байна.



4. ОХУ-ын Холбооны хурлын Холбооны Зөвлөлийн дарга хатагтай Валентина Ивановна Матвивинко Монгол Улсын УИХ-ын даргын урилгаар өнгөрсөн сарын 22-23-нд Монгол Улсад айлчлалаа. Валентина Ивановна Матвивинко Ерөнхий сайд Н.Алтанхуягт бараалхав. Энэ үеэр Ерөнхий сайд “ОХУ-тай уламжлалт, сайн хөршийн, бүх талын найрсаг харилцааг стратегийн түншлэлийн түвшинд гүнзгийрүүлэн хөгжүүлэх нь Монгол Улсын гадаад бодлогын тэргүүлэх

чиглэлийн нэг” хэмээн байр сууриа илэрхийллээ. Энэ хүрээнд Монгол Улс, ОХУ-ын стратегийн түншлэлийг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр байгуулахаар



урьдчилсан байдлаар төслийг боловсруулж, Оросын талд өгсөн болохыг хэллээ.

Монгол Улс, ОХУ-ын хооронд дипломат харилцаа тогтоогоод 93 жил өнгөрсөн байна. Хатагтай Матвивинкогийн айлчлал нь түүний Холбооны Зөвлөлийн даргын хувиар хийж буй анхны албан ёсны айлчлал. Айлчлалын хүрээнд хоёр тал визтэй зорчих журмыг цуцлах нэгдсэн байр сууринд хүрчээ. Энэхүү яриа хэлэлцээ нь таван жил үргэлжилж буй. Энэ оны наймдугаар сард Халх голын байлдаанд ялалт байгуулсны 75 жилийн ойн баяр тохиож байгаа. Түүхт ойд ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путин оролцох бөгөөд энэхүү айлчлалын үеэр дээрх хэлэлцээрт хоёр тал гарын үсэг зурах юм. Ингэснээр яриа хэлэлцээр баталгаажих аж.

5. БНАСАУ-ын Аялал жуулчлалын Ерөнхий газрын дэд дарга Мүн Дэ Гил тэргүүтэй төлөөлөгчид зургадугаар сарын 20-25-нд Монголд ажлын айлчлал хийж, “Монгол Улсын аялал жуулчлалын салбарын хөгжлийн чиг хандлага, цаашид баримтлах бодлого” сэдэвт семинарт оролцлоо. Тус ажлын айлчлал нь өнгөрсөн онд Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн БНАСАУ-д хийсэн төрийн айлчлалын дагуу хэрэгжжээ.

Айлчлалын зорилго нь Монгол Улсын аялал жуулчлалын салбарт баримталж буй бодлоготой танилцах байв. Үүнээс гадна тус салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, харилцан туршлага солилцоход чиглэжээ. Мөн манай улсын аялал жуулчлалын гол бүс, газруутай танилцахаас гадна БНАСАУ-аас аялал жуулчлалын салбарт баримтлаж буй хөрөнгө оруулалтын бодлогыг Монголын хувийн хэвшлийнхэнд танилцуулж, боловсон хүчин хамтран бэлтгэх асуудлаар СЭЗДС-д зочилжээ. 2011 онд манайх БНАСАУ-ын Үндэсний аялал жуулчлалын газартай хамтран ажиллах хамтын ажиллагааны гэрээг байгуулсан байдаг. Тус улстай манай улс найрамдалт харилцаа тогтоосны 65 жилийн ой өнгөрсөн онд тохиосон.

6. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын шадар туслах, НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөрийн захирагчийн орлогч бөгөөд Ази, Номхон далайн бүсийн товчооны захирал ноён Хаолянь Шу энэ оны зургадугаар сарын 16-20-нд Монголд хөл тавилаа. Ноён Х.Шу Монгол Улс НҮБ-ын хамтын ажиллагаанд сэтгэл ханамжтай байгаагаа илэрхийлж, хүний эрхийг баталгаажуулах, ардчилсан засаглалыг хөгжүүлэх тухай Мянганы хөгжлийн ес дэх зорилгыг Монгол Улс амжилттай хэрэгжүүлж байгааг онцлон тэмдэглэжээ. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр Монгол Улсын хөгжлийн үйлсэд хандивлагч бус түншийн хувиар нягт хамтран ажиллахаа илэрхийллээ. ■

УРД ХӨРШ

# СИ ЗИНЬПИН: ХАМТДАА ХОЖИХ ЁСТОЙ

Б.ТОГТОХ


БНХАУ-ын дарга Си Зиньпин ирэх сарын дундуур манай улсад албан ёсны төрийн дээд хэмжээний айлчлал хийх гэж байна. Дэлхийн хүн амын тавны нэгийг эзлэх өмнөд хөршийн удирдагч Си Зиньпин төрийн тэргүүн болоод анх удаа манай улсад зочлох гэж байгаа нь энэ. Өмнө нь тэрбээр 2008 онд дэд ерөнхийлөгч байхдаа ирж байсан удаатай. Түүний энэ удаа хийх гэж буй айлчлал манай хоёр улсын хувьд түүхэн үйл явдал. Тэр тусмаа манай улсын хувьд нөлөө бүхий хөршийн төрийн тэргүүн айлчлах нь гадаад харилцаа талаас нэр хүндийн хэрэг.

Гурван их наяд ам.долларын гадаад валютын нөөцтэй, манайхаас даруй 860 дахин том эдийн засагтай, дэлхийн эдийн засгийн супер гүрэн Хятадын шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэгч ийн Улаанбаатарт хөл тавих нь тодорхой боллоо. Түүний айлчлалын бэлтгэл ажлын хүрээнд тус улсын Гадаад хэргийн сайд Ван И өнгөрсөн сард ирээд буцсан.

Си Зиньпиний айлчлал хоёр улсын дипломат харилцаа тогтоосны 65 жил, Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны гэрээг шинэчилсний 20 жилийн ойн тохиож байна. Хагас жарны турш найрсаг харилцааг бэхжүүлсэн хоёр орны хувьд худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөн хүрээнд хөгжүүлж ирсэн.

БНХАУ сүүлийн 14 жил манай улсын гадаад худалдаа, хөрөнгө оруулалтад тэргүүлэх байр суурьтай оролцож буй. Ингэснээр 2010 онд 3.3 тэрбум хүрч 100 дахин, 2011 онд хоёр орны худалдааны нийт хэмжээ 6.4 тэрбум ам.долларт хүрч 2010 онтой харьцуулахад хоёр дахин өссөн байна. Энэхүү худалдааны эргэлтийг 10 тэрбум ам.долларт хүргэх зорилтыг хоёр талаас дэвшүүлэн тавиад буй.

Ерөнхий сайд Н.Алтанхуяг өнгөрсөн онд БНХАУ-д албан ёсны айлчлал хийж Хятадын удирдагч Си Зиньпинтэй уулзсан. Үүний дараа буюу энэ оны тавдугаар сард Шанхай хотод болсон Азид хамтын ажиллагаа, итгэлцлийг бэхжүүлэх бага хурлын дээд төвшний уулзалтын үеэр Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж БНХАУ-ын дарга Си Зиньпинтэй уулзаж хоёр талын харилцаа, хамтын ажиллагааны өргөн хүрээтэй асуудлаар санал солилцсон. Энэ үеэр “БНХАУ нь Монгол Улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, Монголын ард түмний сонгосон хөгжлийн замыг хүндэтгэнэ. Хоёр улс харилцан ашигтай харилцаж, хамтран хөгжиж, хамтдаа хожих ёстой” хэмээн Хятадын удирдагч албан ёсны байр сууриа илэрхийлсэн.



Хоёр улсын хооронд 2011 онд стратегийн түншлэлийн харилцааг тогтоосон бөгөөд Ерөнхий сайдын айлчлалаар стратегийн түншлэлийг хөгжүүлэх дунд, урт хугацааны хөтөлбөрийг байгуулсан. Энэ үндсэн дээр хоёр талын улс төр, эдийн засаг, худалдаа, соёл, боловсрол, шинжлэх ухаан, хүмүүнлэг зэрэг салбарт харилцаа, хамтын ажиллагаа идэвхтэй өрнөж байна. Монгол, Хятадын стратегийн түншлэлийн харилцааны гол тулгуур нь худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа гэж талууд үздэг. БНХАУ нь Монгол Улсын гадаад худалдааны хамгийн том түнш төдийгүй хамгийн том хөрөнгө оруулагч.

Монголын нийт экспортын 92 орчим хувь, гадаад худалдааны эргэлтийн 54 хувийг урд хөрш эзэлж байна. БНХАУ-ын Гадаад хэргийн сайд Ван И “Монгол Улсад хийх БНХАУ-ын дарга Си Зиньпинийн айлчлал эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаа, уул уурхай, дэд бүтэц, үйлдвэрлэл зэрэг бүтээн байгуулалтын томоохон төслүүдийг эхлүүлж, Монголын эдийн засгийг эрчимжүүлэх болно” гэсэн. Түүний хэлсэн үг Си Жиньпинийн айлчлал Монголын эдийн засагт чухал нөлөөтэй болохыг илтгэх аж.

Өнгөрсөн тавдугаар сарын 21-нд Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Си Зиньпинийг Монгол Улсад айлчлахыг уриад “Таны манай улсад хийх айлчлал хоёр орны харилцааг шинэ шатанд гаргана гэдэгт итгэлтэй байна” хэмээсэн. БНХАУ-ын төрийн тэргүүн 11 жилийн дараа Монголд айлчлах гэж байна. ■

## ХОЙД ХӨРШ

## В.В.ПУТИН БА ХИЙН ХООЛОЙ

## Б.АЛТАЙ

БНХАУ-ын удирдагчаас гадна ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путин ирэх сард манай улсад албан ёсны төрийн айлчлал хийх нь. Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж В.В.Путиныг Халх голын ялалтын 75 жилийн ойг тохиолдуулан айлчлахыг урьсан. Түүний урилгыг хойд хөршийн төрийн тэргүүн талархан хүлээн авсан ч тухай үед тодорхой хариу өгөөгүй. Ерөнхийлөгчийн зүгээс Оросын талд түүхт ойг хамтран тэмдэглэх хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн.

Шанхай хотноо өнгөрсөн тавдугаар сард болсон Ази, Номхон далайн бүс нутгийн энх тайван, аюулгүй байдлын хамтын ажиллагааны Дээд хэмжээний уулзалтын үеэр Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж В.В.Путинтэй албан ёсны уулзалт хийх үеэр ийм яриаг өрнүүлж амжсан. Үүнээс гадна төмөр замын транзит тээврийн асуудлаар гурван талын уулзалтыг Улаанбаатар хотноо зохион байгуулах саналтай байгаагаа ч В.В.Путинд дуулгасан. Үүний дараахан ОХУ-ын Санкт-Петербург хотод болсон Олон улсын эдийн засгийн форумын үеэр В.В.Путин Ерөнхий сайд Н.Алтанхуягт Халх голын дайнд ялсны 75 жилийн ойд оролцохоо албан ёсоор мэдэгдсэн юм.

Дэлхийн худалдааны байгууллагын 156 дахь бүрэн эрхт гишүүн, бөмбөрцгийн гурав дахь том эдийн засагтай ОХУ өнөөгийн хөгжилдөө сэтгэл гонсгор, манай улс дэлхийн хуурай газрын наймны нэгийг эзлэх хойд хөрштэйгээ хамтарч “Талын зам” төсөл хэрэгжүүлэхээр зэхэж байна. ОХУ, БНХАУ, цаашлаад Европ, Азийг холбох авто болон төмөр зам, хийн хоолой, эрчим хүчний шугам, нефтийн транзит тээврийн коридор бий болгохоор ОХУ-ын холбогдох албаны хүмүүстэй нэг бус удаа манай сайд нар уулзаад байгаа. Уг төсөл “амьдрах” эсэхийг хоёр хөрш шийдэх юм. Сүүлийн жилүүдэд манай хойд хөрштэй хийж буй худалдааны эргэлт гурав дахин өссөн байна. Гэвч өнгөрсөн жил худалдааны эргэлтийн хэмжээ 16 хувиар буурч, 1.6 тэрбум ам.доллар болсон байна.

Их наймын гишүүн, цөмийн зэвсэгтэй таван орны нэг нь ОХУ. Валютын нөөцөөр Хятад, Японы дараа орж буй. Улсын өр нь ДНБ-ий 10 хүрэхгүй хувийг эзлэх тус улс 143 сая хүн амтай. Нефть, байгалийн хийн дэлхийн зах зээлийн үнийн өсөлт ОХУ-ын экспортын орлогыг огцом нэмэгдүүлсээр байгаа. ОХУ Евроазид нөлөөгөө бэхжүүлэх арга хэмжээг тууштай авч байгаа бөгөөд хуучин Зөвлөлийн хүрээнд нөлөөгөө сэргээх чиглэлд системт ажлыг өрнүүлээд эхэлсэн. Энэ нь Украины үйл явдлаар тод илэрлээ.

ОХУ ирэх оноос Евроазийн эдийн засгийн холбоог байгуулахаар бэлдэж байгаа аж. Хүнсний аюулгүй байдлыг хангах хүрээнд 2020 он гэхэд ОХУ нь 30-40 сая тонн улаанбуудай экспортлохоор төлөвлөж буй. Мөн хойд мөсөн



далайгаар хийх тээвэр зуучыг хөгжүүлсэнээр Ази, Европыг холбосон төмөр замаар хийх тээврээс 2020 он хүртэл 670 тэрбум ам.долларын ашиг олох боломжтой гэсэн судалгаа бий. ОХУ нь дэлхийн нефтийн илэрсэн нөөцийн 13 хувь, байгалийн хийн 34 хувийг дангаар эзэмшиж байна. Энэ нь хойд хөршийн хувьд эрчим хүчний томоохон тоглогч байх хангалттай боломж.

ОХУ, БНХАУ-ын хооронд тавихаар төлөвлөж буй байгалийн хийн хоолойг өөрийн улсын нутаг дэвсгэрээр дайруулах хүсэлтээр Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд Оросын талд хандсан. Өнгөрсөн тавдугаар сарын 24-ны өдөр Шанхай хотноо 2018 оноос эхлэн 30 жилийн турш жилд 61 тэрбум шоо метр байгалийн хий худалдах, худалдан авах гэрээнд манай хоёр “мөнх”-ийн хөрш гарын үсэг зурсан. Хойд хөршийн өргөн уудам нутгаас өмнөд хөрш рүү хий дамжуулахад хамгийн дөт зам нь Монголын тал хээрийн бүс.

ОХУ-ын байгалийн хийн ордуудаас БНХАУ-д хүргэхийн тулд 4000 км хийн хоолой барьж байгуулах шаардлагатай. Харин Монголын нутгаар дамжуулан тээвэрлэхэд 1500 км хийн хоолой байгуулж, хөрөнгө оруулалтын зардлаа хэмнэх боломжтой. Нийтдээ 400 тэрбум ам.долларын үнийн дүн бүхий гэрээнд Монгол Улс гуравдагч “түнш”-ээр оролцох талаар ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путинд санал хэлэхэд “Асуудлыг судалъя” гэж нааштай хандсан. Тэгвэл Монголд хийх гэж буй В.Путины айлчлалын нэг халуун сэдэв нь байгалийн хийн хоолойтой холбоотой асуудал байх нь.

Шанхайд үзэглэсэн хөршүүдийн гэрээ Монголын эдийн засагт жин дарахуйц мөнгөний урсгал. Тиймээс Монголын ашиг сонирхолд хөршүүд хэрхэн ханддаг нь хийн хоолойн зураг хэрхэн шийдэгдэхээс тод харагдах юм. В.В.Путин 2009 онд Ерөнхий сайд байхдаа манай улсад айлчилж байв. ■

## ЯРИЛЦЛАГА

# Д.БЯМБАСҮРЭН: УИХ, ЗАСГИЙН ГАЗАР, ТӨВБАНК ХЯМРАЛЫН ҮҮСГҮҮР ГЕНЕРАТОР БОЛООД БАЙНА

С.БАТЗАЯА

*Монгол Улсын Ерөнхий сайд асан Дашийн Бямбасүрэнтэй эдийн засаг, нийгмийн холбогдолтой цаг үеийн асуудлаар ярилцлаа.*

-Монгол төрийн бодлого маань сүүлийн үед хаашаа чиглээд байна вэ гэдгийг ойлгохоо болилоо.

Хариултаа хүлээж буй олон асуудлын гогцоог тайлахаар таныг зорьж ирлээ. Эдийн засгаа ингэж, тэгж ч сайжруулна гээд баахан хуулийн төсөл батлуулахаар Засгийн газар зүтгэж байна. Үүний нэг нь Ашигт малтмалын тухай хууль.

-Ашигт малтмал ашиглах бодлогын асуудлыг ард түмнээс холдуулж, зөвхөн эрх бүхий албан тушаалтнууд шийдэх тэр зам руу түлхэж байна. Энэ хуульд орсон нэг зүйл нь Монголын өв баялгийг үнэгүйдүүлэх тухай заалт. Одоогийн Ашигт малтмалын тухай хуулийн 47.3-т нөөц ашигласны төлбөрийн тухай тусгасан. Нөөц ашигласны төлбөр гэдэг бол Монголын үндэсний баялгийг аж ахуйн нэгжүүд авч ашигласны үнэ юм шүү дээ. Барилга барихдаа тоосго худалдаж авдагтай адил тэд Монголын эрдэс баялгийг худалдаж авч байна гэсэн үг. Гэтэл манайхан үүнийг татвар гэж ойлгоод баялаг эзэмшиж байгаа хүмүүсийнхээ өмнө очоод “Уучлаарай. Бид татвараа ихдүүлчихэж. Чамайг гомдоочихов уу. Татвараа багасгаад өгье” гэдэг. Зүй нь бол баялгийнхаа үнэлгээг орд газраар тогтоогоод тендер зарлахдаа үүнийгээ зарладаг байсан бол ашиглах боломжтой нь орж ирнэ. Үндэсний эрх ашгаа ингээд хохироогоод байгаа юм. Шинэ хуулиар нөөц ашигласны төлбөрийг бүрмөсөн хассан байна. Стратегийн орд газрыг



Фотог Э.Зоригт

авч үлдэх үү, эсвэл тодорхойлолтыг нь явцуу болгосноор Монголын эдийн засагт нөлөө бүхий орд газруудыг хэн нэгэн дураараа ашиглаж зарцуулах боломж бүрдэнэ. Асуудалд иймэрхүү

байдлаар хандаад байна. Энэ хуулийн өөр нэг ноцтой асуудал бол лицензийг хүчингүй болгож, нөхөн олговрыг нэг жилийн дотор олгоно гэсэн байна. ▶

► **-Лиценз хэний гарт очиж байгаа нь хамгийн аюултай. Хувь хүн өөрийн нэр дээр лиценз аваад гадныханд худалдахыг үгүйсгэхгүй шүү дээ.**

-Би ганцхан жишээ хэлье. 2004 оны есдүгээр сарын 30-нд Хэнтий аймгийн ажлаасаа чөлөөлөгдөж буй Засаг дарга нь ганцхан өдрийн дотор 80 тусгай зөвшөөрөл олгосон байдаг юм. Үүний 28-ыг нь нэг компани, 12-ыг нь Туяа гэх хүн авсан байдаг. Хэн дуртайд нь газар олгож, лиценз өгөөд байсан. Лиценз эзэмшиж буй хүмүүс банкны барьцаанд тавих, дамлаж худалдах, эргэлтэд оруулах байдалд орсон. Одоо үүний учир замбарааг нь олоход хэцүү байдалтай байна шүү дээ.

**-Эдийн засгийн ил тод байдлын тухай хуулийн төслийг Засгийн газар УИХ-д өргөн мэдүүлээд байна. Үүнийг олон нийт цагаан захтнуудад зориулсан хууль болох нь гэж шүүмжилж байгаа. Та хуулийн төслийг олж үзэв үү?**

-Эгэл жирийн иргэн хүн гадаадын оффшор бүсэд данс нээгээд мөнгө хадгалахгүй. Энэ цагаан захтнуудын хийх ажил. Татвараас зугатааж гадагш гарсан, давхар гэрээ хийж баялгаа хямдруулах маягаар үнэлэн татвараа бага төлсөн, мөнгөө гадагш гаргасан хүмүүсийн тухай асуудал юм. Өршөөл үзүүлэх тухай хууль байдаг. ОХУ гэхэд хоёр удаа өршөөл үзүүлж байлаа. Гэхдээ үүний цаана тодорхой үнэлгээ байх ёстой. Тухайлбал, өндөр албан тушаалтан хүн гадаадад оффшор данстай байж байгаад өршөөлд хамрагдвал тэр бизнес эрхлэгчидтэй адил байж болохгүй. Төрийн бүх албан тушаалаас хөөгдөх хэрэгтэй. Төрийн алба хаших эрхийг нь ч хасах ёстой. Бизнесээ хийгээд яваг. Өршөөлийн дараа шударга болоод татвараа төлөөд явна биз. Түүнээс Сангийн сайд шигээ оффшор бүсэд данс нээгээд дэлхийн шившиг болчихоод УИХ-ын гишүүн хэвээр суугаад байж болохгүй.

**Эдийн засгаа ямар нүдээр хардаг улсууд юм бэ**

**-Монголын эдийн засаг ямар байдалтай байгааг Та хамгийн сайн мэдэж байгаа. Доройтсон эдийн засгийг 100 хоногт эрчимжүүлэхээр**

**Засгийн газар ажиллаж байна. Та Ерөнхий сайдаар ажиллаж байсан хүн. Энэ асуудлыг хэрхэн харж байна вэ?**

-Монголын эдийн засаг яагаад хүндрэв гэдгийг эхлээд олох хэрэгтэй. Төрийн бодлого буруу байснаас эдийн засаг ийм байдалд хүрсэн гэж би ойлгодог. УИХ, Засгийн газар, Төвбанк хямралын үүсгүүр генератор болоод байна. Тухайлбал, төгрөгийн ханш яагаад унав. Хэн бүхэнд тодорхой гурван асуудал бий. Нэгдүгээрт, Монголбанкнаас дөрвөн их наяд төгрөгийн мөнгөний нийлүүлэлт хийлээ. Хоёрдугаарт, өнгөрсөн жил Монголын гадаад худалдааны төлбөр хоёр тэрбум ам.долларын алдагдалтай гарлаа. Импорт нь экспортоосоо энэ хэмжээгээр давсан гэсэн үг. Ам.доллар хомсдоод ирэхээр үнэд орох нь зах зээлийн зарчим биз дээ. Гуравдугаарт, Монголын төр орон сууцны хөтөлбөр зарлаад байгаа мөнгөө барилгын салбар руу хийсэн. Энэ нь хоёр үр дагаврыг бий болгосон. Эхнийх нь, мөнгөний эргэлтийг удаашруулсан, дараа нь гаднаас 30-40 мянган ажилчин авчирч, цалинжуулсан. Тэднийг ажиллуулах, материал авахад тэрбум гаруй ам.доллар зарцуулсан. Үүнээс болж валютын нөөц багассан. Адаглаад энэ асуудлуудаа шийдэж чадсангүй. Тэгсэн хэр нь 100 хоногийн хөтөлбөр гэж зарлаад байна. Энэ бол Н.Алтанхуягийн Засгийн газрын насыг уртасгах тухай 100 хоног. Ийм хугацаанд эдийн засаг сэргэнэ гэдэг эргэлзээтэй. Зарласан, тунхагласан хөтөлбөр нь даанч арчаагүй. Эдийн засгаа ямар нүдээр хардаг улсууд юм бэ гэдгийг ойлгоход төвөгтэй. Эдэнд нэг л үндсэн нэр томъёо ойлголт бий болсон. Гадаадын хөрөнгө оруулалт зугтлаа, хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлнэ гэдэг болж.

**-Монголчууд өөрсдөө бүтээх ёстой гэсэн үг үү?**

-Улс орны эдийн засгийг өөрийнх нь бизнес, үйлдвэрлэл, ажил эрхлэгчид авч явдаг. Гэтэл манайхан гаднын баячуудын гарыг долоож, амьдрахаас өөр аргагүй боллоо гэсэн сэтгэлгээтэй. 1911 онд Богд Хаант Монгол Улс тусгаар тогтнолоо тунхагласны дараа тэр үеийн Хятадын Ерөнхий сайд Богдод захидал бичсэн байдаг юм. Захианд "Та нар биеэ дааж

амиа тэжээж авч явж чадахгүй, гуу жалгаар дүүртэл үхнэ" гэсэн байж. Энэ номлол 100 жилийн дараа Монголд дахин сэргэж байна. Өөрөөр хэлбэл, монголчууд бие дааж эдийн засгаа авч явж чадахгүй гадаадын хөрөнгө оруулагчдын гарыг долоож байна шүү дээ. Энэ бол үнэхээр харамсалтай. Үүний цаадахыг бодоход, ардчилсан Монголын ард түмний итгэл, горьдлогыг хүлээж 20 гаруй жил ардчиллын төлөө гэж ард түмний сэтгэлийг ухуулж ирсэн улс төрийн хүчин төр барингуутаа эргээд ийм арчаагүй байдалд орж байна. Эндээс юу харагдаж байна вэ гэхээр ардчилал гэдэг сайн төр байхын баталгаа биш юм. Ардчиллын нөхцөлд сайн төрийг бүтээхийн тулд огт өөр шаардлага, ухаан хэрэгтэй гэдгийг харуулж байна.

**-Ямар ухаан хэрэгтэй байна. Одоо бид энэ шавраас явал гарах вэ?**

-Одоогийн улс төрийн бодлого хэвээр байхын бол шавраас гарахад үнэхээр хэцүү. Улам хүндэрнэ. 100 хоногийн хөтөлбөр зарласны дараа тэд импорт 620 орчим сая ам.доллараар буурлаа гэж байна. Гадны ажилчдыг ажиллуулдаг газар руу хийдэг мөнгөө хэмнэсэн бол яая гэхэв. Энэ хэмнэлтийн ихэнх нь техникийн бараа байгаа. Тоног төхөөрөмж, техникийн бараа гэдэг чинь жинхэнэ хурдан эргэлтэд орж, баялаг бүтээдэг хэрэгсэл. Үүний импорт буурч, баячуудын Улаанбаатараар дүүрэн босгож байгаа гэрэлт хөшөө сүндэрлэж, мөнгө идсээр л байна. Барилгын салбарт оруулсан хөрөнгө мөддөө эргэж нөхөгддөггүй. Нэг байшин барихын тулд дор хаяж гурван жил зарцуулна. Босгохын тулд жил бүр хөрөнгөө газар руу хийнэ гэсэн үг. Ийм бодлого явуулж байхад засарна гэхэд хэцүү. Төр ард түмэн рүү нүүрээ харуулсан бодлого явуулах хэрэгтэй байна. Тэгэхгүйгээр газар, ашигт малтмалыг чинь хувааж худалдана гээд хямралаар далимдуулж хулгайчын арга хэрэглэж болохгүй. Ингэвэл улам хүндрээд л байна.

**-Чуулган завсарлахаас өмнө хуулийн төсөл, тогтоолын төслүүдийг бөөндөөд батлуулчих гээд эрх баригчид зүтгэж байна. Өрийн удирдлагын тухай хуультай болж буй нь сайн хэрэг. Гэхдээ цоорхойтой хууль баталвал** ►

► **Үндэсний эрх ашиг дахиад хөндөгдөх нь ээ. Яах вэ?**

-Өрийн удирдлага, хяналт гэдгээ манай улс аль эрт тавиад туучихсан шүү дээ. Монголын хуулиар улсын өр ДНБ-ий 40 хувиас хэтэрч болохгүй гэсэн заалттай. Энэ хуулийг УИХ-д сууж байгаа нөхдүүд баталсан. Үүнийгээ хоёр жилийн өмнөөс зөрчөөд эхэлсэн. Шинэ Их хурал бүрдэнгүүтээ өөрсдөө Засгийн газарт таван тэрбум ам.долларын өрийн бичиг гаргах эрх өгсөн. Хууль нэгэнт зөрчигдсэн. Одоо эрх баригчид өрийн хэмжээг ДНБ-ий 70-90 хувьд хүргэх гэж байна. Үүнийгээ ард түмэнд буян үйлдэж байгаа мэтээр ярьж байна. Өртэй хүн өөдөлдөггүй гэдэг үг үнэн шүү. Үүнийг бид мартаад байна. Өмнө нь Олон Улсын валютын сан, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкнаас хөнгөлөлттэй зээл авдаг байсан. Япон, Германаас ч мөн адил. Гэтэл одоо авсан бондын мөнгө маш хатуу нөхцөлтэй зээл. Сүүлдээ улс орон ямар ч байдалд орж болзошгүй. Бид Грек, Исландыг харлаа. Европт сүүлийн хэдэн жил юу болов. Гэтэл одоо манай эрх баригчид өр тавих гээд шунаад байна. Тэдний цаад бодол нь өрийг ирээдүйн монголчууд төлнө. Тиймээс энэ мөнгийг өнөөдөр би хувааж идээд алга болно гэсэн санаа байна. Яана даа. Монголд одоо улсын төсөв гээд нэг сав байна. Сангийн яамны мэдэлд. Дараа нь Хөгжлийн банк, бондын мөнгө гээд салангид зүйлүүд бий. Үндсэндээ Монголын мөнгөний болон зээл санхүүгийн бодлого задарсан. Үүнийгээ эмхэлж чадахгүй, улам өрөө нэмье гээд байна. Энэ бол улс орныхоо ирээдүйг харж чадахгүй байгаа хүмүүсийн явуулж буй бодлого.

**-2017, 2018 онд бондын мөнгөний түрүүчийг төлнө. Үүнийг яаж төлөх бол гэхээр л...?**

-Өрийн удирдлага дээр нэлээд хатуу гараар тооцоотой хандахгүй бол бид барьц алдаж мэдэхээр байгаа. Оюутолгойгоос учиргүй их мөнгө олно гээд хүлээгээд байсан юу ч үгүй боллоо. Хамгийн сүүлчийн жишээ гэхэд Иракт байдал хүнд болоод шатахуун, нефтийн үнэ нэмэгдэх хандлагатай байна. Энэ Монголын эдийн засагт том цохилт болно. Энэ бүхнийгээ харж, эзний ёсоор төсөөлөхгүй бол идээд, зээл аваад байа гэсэн санал санаачилга хол

явахгүй. Ийм нөхцөлд монголчууд өөрсдөө үгээ хэлэх цаг ирэх байх.

**Хувийн өмчийн монополь төрийнхөөс долоон дор**

**-Төрийн өмчийг хувьчлах талаар Засгийн газар тогтоолын төсөл өргөн барилаа. Үүнд МИАТ “Багануур”, “Шивээ-Овоо” зэрэг төрийн өмчит томоохон компани багтсан байна. Нөгөөтэйгүүр “Эрдэнэт” үйлдвэр рүү чиглэсэн бодлого биш байгаа. Өмч хувьчлах цаг нь одоо мөн үү?**

-Төрийн өмчийн объектууд эрх мэдэлтнүүдийн шахааны бизнес болчихсон. Бид дулааны IV цахилгаан станцад 15 сая ам.долларын ажлыг 49 сая ам.доллараар хийж байсныг мэднэ. Зардлаа хэрэглэгчдэд үүрүүлээд явж байсан. Тэндээс нь эрх мэдэлтнүүд хувааж иддэг. Ер нь төрийн өмчид хянуур хандах ёстой. Төрийн өмч Монголын эдийн засагт цар хэмжээ, зах зээлийн багтаамжтай холбоотой үүссэн үүсмэл монополюуд. Тухайлбал, IV цахилгаан станцыг хувьчилчихвал Монголын эрчим хүч монополийн гарт очно. Хувийн өмчийн монополь төрийн өмчийнхөөс долоон дор байдаг. Үүнийг бодохгүй байж болохгүй. Жишээ нь ус, эрчим хүчний газрууд хувийнх болчихвол дуртай цагтаа тасална. Тэгэхээр зах зээлийн зарчмаар ажиллаж хэрэглэгчдэд үйлчлэх тухай асуудал хөндөгдөнө. Үүнд чиглэсэн механизмаар дутаад байгаа юм. Төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн захирлыг нэг сонгуулийн дараа сольдог. Салбараа мэддэггүй, мэргэжлийн бус хүмүүс байдаг. Үүнээс гарах аргаа хувьчлал гэж хэлж байна. Хувьчлалд одоо болгоомжтой хандах цаг болсон. Улс орны нийтлэг эрх ашгийн төлөө үйлчилдэг аж ахуйн нэгжүүд төрийн өмчдөө байх ёстой. Төмөр зам, эрчим хүч, усан хангамж гэх мэт. “Эрдэнэт”-ийн асуудал тодорхой бүлэг хүмүүсийн шүлсийг гоожуулсаар хориод жил боллоо. Энэ үйлдвэрийг хувьчлахад их сонин. Манай талд 51, ОХУ-д 49 хувь байгаа. Монголын талын эзэмшиж байгаа хөрөнгийн хоёр хувийг хувьчлахад түүнийг эзэмшиж байгаа хүн дунд нь тоглож эхэлнэ. Өөрөөр хэлбэл, нэг Оросын талтай нийлээд эсвэл Монголын талтай уулзаад л. Тиймээс

болгоомжтой хандах ёстой.

**-Яг үүнтэй адил стратегийн ордуудыг хувьчлах талаар ярьж байна. Монголын ард түмэн бүгдээрээ хүртэх ёстой баялгийг нэг хүн “идээд” явж болохгүй биз дээ. Цагаан суваргын ордоор жишээ татъя л даа.**

-Цагаан суваргыг социализмын үед ашиглахаар бэлдэж, ТЭЗҮ-г нь хийж байв. Үүнийг иж бүрэн ашиглах тухай асуудлыг Тавантолгойн ордтой зэрэгцүүлж ярья. Тавантолгойг манайхан 5-6 хуваачихлаа. Цогцоор нь ашиглана гэдэг дэд бүтэц, технолгийн нэгдсэн бодлого, нийгмийн болон зах зээлийн нэгдсэн бодлого явж байж хэрэгжих ёстой. Тэгэхгүй хуваагаад хаячихаж болохгүй. “Цагаан суварга” дээр хуулиа мөрдөө гэвэл улсын төсвөөр манайхан өр тавьж байж хайгуул хийсэн учраас улс 51 хувийг нь эзэмшинэ гэсэн хуулиараа явах ёстой. Монголчууд сонгууль болохоор баяр хөөр болж, хэдэн олигорхиудаа толгой дээрээ залдаг. Тэд эргүүлээд энэ мэтээр Монголоо хувааж идэхээр ярьцгаадаг.

**Монгол төрийн бодлогыг бүхэлд нь аваад үзвэл, улсаа үнэ хямдруулж худалдах гэж байна**

**-Засгийн газраас өргөн мэдүүлсэн Газрын тухай хууль ард иргэдийн эсэргүүцэлтэй тулгарсан учраас эргүүлэн татлаа. Энэ асуудалд таны байр суурийг сонирхмоор байна.**

-Монгол Улсын Үндсэн хуульд бүх ард түмний мэдэлд байна гэж заасан хоёр зүйл байдаг. Нэг нь төрийн бүх эрх ард түмний мэдэлд байхаар заасан бол нөгөөх нь газар, түүний хэвлийн баялаг юм. Манайхан хууль эрхзүйн орчноо өөрчилж шинэчлэхдээ бүх ард түмний мэдэлд гэх Үндсэн хуулийн заалтыг яаж хэрэгжүүлэх талаар бодоогүй явж ирсэн. УИХ-ын танхим дотор хэдэн хүн хэлэлцэж байгаад хууль гаргадаг. Харамсалтай нь, энэ байдал Газрын тухай болон Ашигт малтмалын тухай хуулиар үргэлжиллээ. Монголын төрийн баримталж байгаа бодлогыг өнгөрсөн жилийн намрын чуулганаас хойш бүхэлд нь аваад үзвэл улсаа үнэ хямдруулж худалдах бодлого ►

“ ...Төмөр замынхаа цариг дээр ийм олон жил маргалдана гэдэг дэлхийн орнуудаас явуулж буй төрийн бодлогоороо мунхагаар шалгарч, Гиннесийн номонд орох явдал. Төмөр замын царигийн асуудлаа төр шийдэж чадахгүй сууна гэж юу яриад байгаа юм. Тухайлбал, Тавантолгойгоос урд хөрш рүү нүүрс гаргахаар эдийн засгийн тооцоо хийгээд үзвэл нарийн цариг байх нь...”

▶ явж байна. Өмнө нь АНУ-ын судлаач Хятад Монголыг худалдаж авч байна гэж дэлхийн нийтэд зарласан. Бидэнд хэн худалдаж байгаа юм гэсэн асуулт үргэлж үлдэж байсан. Өнгөрсөн нэг жил гаруйн хугацааг харахад, Монголыг монголын төрийн түшээд худалдаж буй байдал харагдаж байна. Газрын харилцааны асуудлыг Үндсэн хуульд нэлээд тодорхой заасан. Гэтэл дуудлага худалдаагаар гадаадын иргэдэд газар эзэмшүүлнэ гэжээ. Юу хэлж байгаагаа тэр хүмүүс сайн ойлгож байгаа. Дуудлага худалдаагаар үнэ хаялцаж авсан хүмүүс минийх гэж хэлнэ. Тэгээд бүр болоогүй 100 жилээр шүү. 100 жилийн дараа одоогийн УИХ-ын гишүүд түүний хүүхдүүд байхгүй гэдэг нь хэнд ч ойлгомжтой. Ингэж Монголын ард түмний ирээдүйг тарамдуулж, Монгол оршихуйд аюул учруулж болохгүй.

Ардчилсан нам өөрийнхөө үзэл санаагаар хүн төрөлхтний үнэт зүйлийг хүлээж авсан улс төрийн хүчин байдаг байх. Гэтэл үндэсний эрх ашиг гэдэг тэс өөр асуудал байдаг. Үүнийг өнөөдөр баяжих шунах хүсэлд хөтлөгдөж, хохироож болохгүй. Газрын тухай болон Ашигт малтмалын тухай хуулийн төслийг энэ чигээр нь явуулбал Ардчилсан намын одоогийн төрийн эрхэнд буй удирдлага, төр засгийн түшээд, маш муу төрийн жишээ болж үлдэнэ. Өөрийнхөө ард түмэн улс үндэстнээ хохироогоод гаднынханд долигонож бялдуучилдаг төрийг муу төрийн гол шинж гэж үздэг. Манайх одоо энэ байдлаар явж байна. Газрын тухай хуулинд олон асуудал тодорхойгүй байна лээ.

#### -Тухайлбал?

-Газрын үндсэн ангилалд ашигт малтмал, газрын тос олборлох газрыг тусад нь оруулсан байсан. Өмнөх хуульд ийм ангилал байгаагүй. Ашигт малтмалын хайгуул олборлолт хийх газар гээд ангилбал тэнд байгаа малчид, орон нутгийнхан газар нутгаа эзэмших эрх хаагдана. Нөгөөтэйгүүр бүх ард түмний мэдэлд байх ёстой гэдгээрээ газартай холбоотой бүх зүйл олон нийтэд ил тод байх ёстой. Үүнийг УИХ төрийн байгууллагууд нь ард түмнээрээ хэлэлцүүлдэг, саналыг нь авдаг байх ёстой. Гэтэл оруулж ирсэн хуульд нь төрийн захиргааны төв байгууллага шийднэ гэж тусгасан байх

жишээтэй. Энэ нь Монголын газар нутаг, ирээдүйг арилжааны хэрэгсэл болгоод одоогийн эрх баригчид шуналынхаа жолоог сул тавьсан гэдгээ харуулж буй хэрэг юм.

**-Газрын тухай маргааныг олон улсын гэрээгээр шийднэ гэсэн зүйл заалт оруулсан байсан. Иргэн хүний хувьд аваад үзсэн ч санаанд багтамгүй санагдах юм.**

-Монголд газрыг яаж ашигладаг билээ, бэлчээрээр, нүүдэл суудал хийж ашигладаг. Аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулчихаад олон улсын гэрээгээр шийднэ гээд тухайн нутгийн ард иргэдийг газар нутгаас нь хөөх нь. 100 жилээр өгнө гэдэг Монголын газар нутгийг тасалж, гадаадынханд эзэмшүүлэх тухай асуудал юм. Хятад улс тухайн үедээ хүчинд автаж Англид Хонконгийг 100, Португальд Макаог 100 жилээр өгсөн. Үүнийгээ эргүүлж авах гэж ямар том асуудалд орж байв. Ийм байдлаар Монголын эрх ашгийг наймаалж болохгүй. Дараагийн орж ирэх хуулийн төсөлдөө маш хянуур хандах нь чухал.

**-Таньтай уулзсаных төмөр замын царигийн асуудлаар асуулгүй өнгөрч болохгүй нь. Өргөн, нарийн гэж 6-7 жил маргалдсаар өнөөдрийг хүрлээ. Та үүнд ямар байр суурьтай явдаг вэ?**

-Төмөр замынхаа цариг дээр ийм олон жил маргалдана гэдэг дэлхийн орнуудаас явуулж буй төрийн бодлогоороо мунхагаар шалгарч, Гиннесийн номонд орох явдал. Төмөр замын царигийн асуудлаа төр шийдэж чадахгүй сууна гэж юу яриад байгаа юм. Тухайлбал, Тавантолгойгоос урд хөрш рүү нүүрс гаргахаар эдийн засгийн тооцоо хийгээд үзвэл нарийн цариг байх нь. Тавантолгойгоос хойшоо Оросын нутгаар дамжаад хагас коксжсон нүүрс гаргая гэвэл өргөн цариг байх нь. Гол асуудал нь төмөр зам хэний өмч байх уу гэдэгт байгаа юм. Манайхан царигийн асуудал гэж төмрийн тухай ярьчихаад эдийн засаг, нийгэм улс төрийн бодлогоо ярихгүй байна. Монголын нутаг дээр байгаа бүх төмөр зам төрийн өмч байна.

**-Ярилцсанд баярлалаа. Танд эрүүл энхийг хүсье. ■**

## ХУУЛЬ

# ӨРӨНД НАЙДАЖ СУУХГҮЙ БОЛНО

## С.ЗАЯА

“Өртэй хүн өөдөлдөггүй” хэмээн манай өвөг дээдэс үеийн үедээ сургамжилсаар ирсэн. Тэр үүднээс монголчууд өр тавих дургүй, үүнээсээ болоод том боломжуудын үзүүрээс атгаж чадахгүй байх нь ч олонтаа. Монголчуудын сэтгэхүйд ийм үзэл бат сууриа эзэлсэн ч аливаа улс орон өр тавихгүйгээр хөгжих боломж тун хомс гэдгийг бид өнгөрсөн 20 гаруй жилийн хугацаанд харлаа. Манайхаас бага газар нутагтай Азийн зарим орон өр тавьж, түүнийгээ баялаг болгон бүтээснээр өндөр түвшинд очтолоо хөгжиж чадсанаас үүнийг харж болох. Тиймээс өр тавьж, улсынхаа хөгжил цэцэглэлтийг урагшлуулахаар Н.Алтанхуягийн Засгийн газар зүтгэсэн. Гэхдээ энэ зүтгэл ажил хэрэг болон амьдрал дээр хэрэгжсэн үү гэвэл дундаас доогуур үнэлгээ өгөхөөр байгаа. Учир нь, Засгийн газрын гадаад өр хоёр жил орчмын хугацаанд 2.8 тэрбум ам.доллараар нэмэгдсэн /зургадугаар сарын байдлаар энэ өрийн хэмжээг 3.172.7 сая ам.доллар болсон гэж зарим эдийн засагч тооцоо хийсэн байсан/ хэр нь эдийн засаг уруудсаар ирсэн. /Энэ 2.8 тэрбум ам.доллар гэдэг бол манай улс 1990-2013 оны хооронд тавьсан өртэй тэнцэж буй мөнгөн дүн юм./

Өр тавиад эдийн засаг сайжраагүй Монгол Улсын 2014 оны нэгдсэн төсвийн тавдугаар сарын гүйцэтгэлээр төсвийн нийт орлого ба тусламжийн дүн 375.3 тэрбум төгрөг буюу 14.6, татварын орлого 396.3 тэрбум төгрөг буюу 17.4 хувиар тасарснаас харж болно. Нэгдсэн төсвийн нийт зарлага ба зээлийн дүн 803.8 тэрбум төгрөг буюу 26 хувиар, дотоод эх үүсвэрээр санхүүжигдэх хөрөнгө оруулалт 429.4

тэрбум төгрөг буюу дөнгөж 34 хувийн гүйцэтгэлтэй гарч. Өөрөөр хэлбэл, хөрөнгө оруулалтын санхүүжилт 66 хувиар тасалдсан байна. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн татвар дөнгөж 37 хувийн биелэлттэй. Тэгэхээр “Хөгжлийн банк”-ны 580, “Чингис” бондын 1.5 тэрбум, “Самурай” бондын 290, Олон улсын банк санхүүгийн байгууллага, түншлэгч орнуудаас 2012 онд 187.3, өнгөрсөн жил авсан 214 сая ам.долларын зээлийг хэрхэн эргүүлэн төлөх вэ. Үүн дээр МИАТ компанид Боинг-767 онгоц худалдан авахад АНУ-аас зээлсэн 121.4, БНХАУ-ын “Хөгжлийн банк”-ны 280 сая ам.долларын өр нэмэгдэнэ. Дээр дурьдсан тоо баримтуудаас нэг л зүйл харагдах. Юу гэвэл, гадаадаас авсан нэг ам.доллараа хоёр болгох бизнес сэтгэлгээ улстөрч сэтэр зүүсэн хүн бүхэнд байх ёстой юм байна. Одоо цаашид яах вэ. Манай улс нэгэнт өрийн хяналтаа алдчихлаа. Хуулиа ч гаргууд сайн зөрчихлөө. Засгийн газрын гадаад, дотоод өрийн хэмжээ ДНБ-ий 62 хувьд хүрсэн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2014 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2015-2016 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн зүйл заалтуудыг ноцтой зөрчиж байна. /Энэ тооцоог олон улсын судалгааны байгууллагууд гаргасан ч Сангийн яам улсын өрийг 43 хувь гэж мэдээлсэн/

Олон Улсын Валютын Сангаас ч үүнийг нотолж, улсын өрийн хэмжээ хуульд заасан босгыг давсан, Монгол Улсын нэгдсэн төсвийн гадуур зарцуулагдаж буй “Чингис”, “Самурай” бонд, “Үнэ тогтворжуулах хөтөлбөр”-ийг төсөвт суулган тооцвол төсвийн алдагдал ДНБ-ий 10.1 хувьтай тэнцсэн тухай тайландаа тусгажээ. Энэ нь

төсвийн тусгай шаардлага болох Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2.-т заасан төсвийн алдагдал дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй байна гэсэн заалтыг хэдийнэ зөрчөөд буй юм.

“Өрийн удирдлагын тухай хуульд бас нэг орсон зүйл нь өр хэзэ үүсгэж болох вэ гэсэн заалт юм. Энэ тухай Төсвийн тухай хуульд өрийг зөвхөн түүний хүү болон зардлыг бууруулах зорилгоор дахин санхүүжүүлэх боломжтой. Дахин санхүүжүүлэх шаардлагатай бол хугацааг сунгахыг хориглоно гэж заажээ.”

**Дахин зээл авах нь уруудсан эдийн засагт “амь тариа” болж чадах уу**

Нөхцөл байдал ийм дээрээ тулчихаад байх үед Засгийн газар Өрийн удирдлагын тухай нэгдсэн хуультай болох ёстой гэж үзэн хуулийн төсөл боловсруулан УИХ-д өргөн мэдүүллээ. Энэ сайн хэрэг. Учир нь, манай улс өр авахаас эхлээд төлж дуусах хүртэл бүхий л үйл явцыг хянадаг хуультай болох гэж байна. Өмнө нь өртэй ▶

► холбоотой зохицуулалтуудыг олон салангид хуульд тусгасан байсан. Харин цаашид өрийн удирдлагын харилцааны бодлого, зохицуулалтыг нэгдмэл байдлаар уг хуулиар зохицуулах юм. Тэгэхээр улстөрчид өрөнд болгоомжтой хандаж, ямар төсөл хөтөлбөрт хөрөнгө оруулбал ашигтай вэ гэдэгт толгойгоо ажиллуулж эхэлнэ. Харин хуулийн төсөлд эдийн засгийг сайжруулах нэрийн дор улсын өрийг 90 хувьд хүргэх зүйл заалт хавчуулчихаж. Өмнөх тавьсан өрөө үр өгөөжтэй зүйлд зарцуулсан нь хомс байтал дахин зээл тавих гэж байгаад сөрөг хүчнийхэн нэлээд шүүмжлэлтэй хандаж байна.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан “улсын өр” гэсэн тодорхойлтыг шинэ хуулийн төслөөр өөрчилжээ. Өөрөөр хэлбэл, улсын өрд багтдаг төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн өрийг тодорхойлолтоос хассан байна. Мөнгөн дүнгээр илэрхийлбэл энэ оны дөрөвдүгээр сарын эцсийн байдлаар төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн өр 1.8 их наяд төгрөг байгаа аж. Шинэ хуулиар энэ дүн улсын өрөө хасагдаж, Өрийн эрсдэлийг аж ахуйн нэгжүүд Компанийн тухай хуулиар өөрсдөө үүрээд явна гэсэн үг. Ингэснээр улсын өрийн хэмжээ багасан шинээр зээл авах боломж бүрдэх аж. Үүнээс гадна улсын өрийн дээд хязгаарыг нэмэгдүүлэх зүйл заалт оруулж. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19.3-т 2014 оноос эхлэн улсын өрийн хэмжээ ДНБ-ий 40 хувиас хэтрэхгүй байхаар заасан. Шинэ хуульд Засгийн газрын өрийн хэмжээг 70, Засгийн газрын баталгааг 20 хувиас хэтрэхгүй байхаар тусгажээ. Нийлээд 90 хувь болно гэсэн үг. Одоогийн мөрдөгдөж буй Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд улсын өр дотор Засгийн газрын өр, баталгаа, төрийн өмчит компаниудын өр зээл, хүү, алданги бүгд багтаж байгаа. Харин Өрийн удирдлагын тухай хуулиар үүнийг өөрчлөх нь.

Энэ тооцоогоор явбал 2016 он гэхэд Монгол Улсын өр 24 их наяд төгрөгт хүрнэ гэдгийг Засгийн газар хийжээ. Төрийн өмчит компаниудын өр орохгүйгээр шүү дээ. Хоёрхон жилийн дараа ийм том тоо гарна. Энэ талаар УИХ дахь МАН-ын бүлгийн Эдийн

засгийн бодлогын зөвлөх Ч.Энхбат “Төрийн өмчит болон орон нутгийн өмчит компаниудын нэлээд хувь нь алдагдалтай ажиллаж байгаа. Улсын өрөөс дээрх компаниудын өрийг хасч байгаа нь тэдэнд эрсдэлийг нь үүрүүлэх сайн талтай ч татвар төлөгчдийн мөнгөөр үүсгэсэн эдгээр аж ахуйн нэгж, өр зээлээ төлж чадахгүй дампуурвал улс хохирол үүрэхийг анхаарах хэрэгтэй. Улсын өр хуулиар заасан дээд хязгаарт тулсан энэ үед Засгийн газар төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдээр дамжуулж гадаад дотоодоос зээл авах боломж нээгдэж байгаа юм” гэв.

## Хөгжлийн нэгдсэн бодлогогүй байж өрөө яаж хянах юм

Засгийн газар энэ хуулийг олонхиороо түрүү барин яаж ийж байгаад батлуулъя гэсэн зорилготой байна. Үүнийг нь УИХ дахь сөрөг хүчнийхэн дэмжихгүй байгаа. Учир нь, улсын өрийг ийн хяналтгүй нэмэгдүүлэх боломж үүсгэх гээд буй зүйл заалтаас болоод тэр. Монгол Улсын нийт гадаад өр энэ оны эхний байдлаар 19 тэрбум орчим ам.долларт хүрчээ. Үүнээс Засгийн газрын гадаад өр 4.5 тэрбум ам.доллар. Өр тавьж болно. Гэхдээ үүнийгээ зөв зохистой зарцуулах ёстой. Гадны орнууд өр тавихаасаа илүүтэй хөрөнгө оруулалтын таатай орчин бий болгон гадаадын компаниудад эрсдэлийг нь үүрүүлэх замаар хөгжиж байна. Гэтэл манайх хувийн хэвшил хийх ажилд төр оролцоод эрсдэлийг нь үүрч яваад байгаа нь буруу гэдгийг Ч.Энхбат хэлсэн.

Эдийн засаг тодорхой хэмжээний санхүүжилтэд үндэслэж хөгждөг. Манай улс өнгөрсөн 2011, 2012 онд нүүрс, зэсийн үнийн өсөлтөөс ахиу орлого олсон учраас төсвийн орлого нэмэгдсэн. Энэ үеэр гадаад, дотоодын томоохон хөрөнгө оруулагчдыг татаж төсөл хэрэгжүүлсэн нь эдийн засгийн эерэг нөлөөллийг бий болгосон гэж эдийн засагчид тайлбарлаж байгаа. Тухайлбал, Эдийн засагч Ч.Хашчулуун “2012, 2013 онд нүүрсний салбар хямарсан учраас өр тавих хэлбэрээр мөнгө оллоо. Манай дээрх хоёр аргаар мөнгө олж буй ч хоорондоо

асар их ялгаатай. Төсвийн санхүүжилт хамгийн хямдхан гэж тооцогддог. Татвараас бүрддэг учир өрөнд ордоггүй. Хамгийн ярвигтай зүйл нь улсын өрөөр санхүүжилт хийвэл үр өгөөжтэй байна уу, үгүй юу гэдэг нь маш чухал байх ёстой. Хувийн хэвшлийнхэн болон гадаадын хөрөнгө оруулагчид үр өгөөжөө өөрсдөө тооцон маш нарийн судалгаа хийдэг” гэв. Харин аливаа улсын хувьд эрсдэлийг тооцож, тодорхой бодлогын дагуу санхүүжилтээ хийх нь чухал байдаг аж. Энэ асуудал өнөөгийн тогтолцоонд дутагдаж буй гэнэ.

Өрийн удирдлагын тухай хуульд бас нэг орсон зүйл нь өр хэзээ үүсгэж болох вэ гэсэн заалт юм. Энэ тухай Төсвийн тухай хуульд өрийг зөвхөн түүний хүү болон зардлыг бууруулах зорилгоор дахин санхүүжүүлэх боломжтой. Дахин санхүүжүүлэх шаардлагатай бол хугацааг сунгахыг хориглоно гэж заажээ. Харин дээрх хуулийн төслөөр энэ зарчмууд тодорхой хэмжээгээр алдагдсан гэнэ. Өрөө төлж чадахгүй бол ямар ч хамаагүй үнээр, хугацаа харгалзахгүйгээр дахин санхүүжүүлэх боломж нээгдэнэ гэсэн үг. Хамгийн ойрын жишээ татвал, 2017 онд бид “Хөгжлийн банк”-ны 580 сая ам.доллар, 2018 онд “Чингис” бондын 500 сая ам.долларыг төлнө. Үүнийг заасан хугацаанд төлж чадахгүйд хүрвэл дахин санхүүжүүлэх хэрэг гарна. Дахин зээл авч, төлнө гэсэн үг шүү дээ. Одоогийн мөрдөгдөж буй хуулиар хүүг бууруулаад хугацааг сунгахгүйгээр дахин санхүүжүүлж болох байсан гэнэ.

Үүнээс гадна дурьдах бас нэг асуудал бол манай улсад Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай нэгдсэн хууль байхгүй. Ийм хуультай болох ёстой гэж УИХ-ын зарим гишүүн үзэн хуулийн төсөл өргөн мэдүүлээд буй ч хэзээ хэлэлцэх нь тодорхойгүй байгаа юм. Хөгжлийн бодлогыг тодорхойлсон хуульгүйгээс гаднаас авсан зээл улс орны хөгжилд зарцуулагдаж буй эсэх нь ч маргаан дагуулсаар байдаг. Хэрэв ийм хуультай болчихвол тооцоо судалгаа гаргаж, ирэх жилүүдэд гаднаас авах мөнгөний босгыг өөрчлөх боломжтой аж. Тэгэхээр Өрийн удирдлагын тухай хуультай хамт Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн төслийг хэлэлцэх хэрэгцээ шаардлага үүсээд байна. ■

## ЯРИЛЦЛАГА

С.БАТЗАЯА

*“Хас” банкны үүсгэн байгуулагч нэрээрээ олонд танигдсан Ч.Ганхуягтай ярилцлаа. Тэрбээр өмнөх Засгийн газрын үед Сангийн дэд сайдын албыг хашиж байсан нэгэн. Унгар улсын Эдийн засгийн их сургууль төгссөнөөсөө хойш Монголын банк санхүүгийн салбарт 20 гаруй жил ажиллаж буй манай лидер залуусын нэг.*



## Ч.ГАНХУЯГ: БИД АФРИКИЙН ЗАМААР ОРЧИХЛОО. ҮҮНИЙ ГАРЦ НЬ УЛСТӨРИЙН ШИЙДЭЛ

**-Монголын эдийн засаг хүндэрсэн гэдгийг эрх баригчид хүлээн зөвшөөрч, баахан ажил хийхээр төлөвлөлөө. Улиг болсон асуулт ч гэлээ монголчууд ямар бодлого явуулбал энэ хүндрэлээс хурдан гарах бол гэдгийг ярианыхаа эхэнд Таниас асуумаар байна?**

-Төрийн бодлогын залгамж чанар, үргэлжлэл алдагдсаны гор гарч байна. Одоо нэг долларын төгрөгтэй тэнцэх ханш 1830 болсон байна, 1700 хүрч байх үе буюу өнгөрсөн оны есдүгээр сард би талбай дээр гараад буруудсан.

Оны сүүлээр ханшийг түр тогтоогоод дахиад алдчихлаа. Миний талбай дээр гардаг үйлдэл дохио болох ёстой байсан. Баяр наадам дөхөөд ирсэн үед дахин анхааруулахад, амралтын өдрөө нэмэх бус дарга нар өдөр шөнөгүй ажиллах хэрэгтэй байна. Чих амраа бодоод амралтын өдрийг нэмээд байх шиг. Монголбанкны удирдлагыг улс төрөөс хараат бус байлгах бодлого алдагдсаны гай гарсаар. Миний мэдэхийн шинэ хууль батлагдсанаас хойш /1996 оноос/ Төвбанкны ерөнхийлөгчийг

улс төрөөс ангид байлгах зорилгоор зургаан жилээр томилно гэсэн заалт хэзээ ч хэрэгжээгүй. Хуулиа гууль болгож, мөрдөхгүй, өөрийнхөө дураар тайлбарладгийн үр дүн юм даа. Мөнгөний бодлого тогтвортой байх ёстой. Монголбанк мөнгөний бодлогоо урьтал болгохгүйгээр төр засгийн өмнөөс очиж, Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх байдлаар асуудалд хандсан нь өнөөгийн нөхцөл байдлыг бий болгосон. Төвбанкны өмнөх ерөнхийлөгч нарт улс төрийн томилгоо хийгдэж байсан ч тэд ▶

▶ бодлогоо хараат бус байлгаж ирсэн. Энэ нь бидний аз байж. Төрийн залгамж халааг хэт их гудамжны улстөрч, популистуудаар дүүргэсэн учраас мэргэжлийн бэлтгэгдсэн боловсон хүчин үгээ хэлэх, ажлаа хийх боломжгүй болсон. Популистууд мэдлэг нимгэн, дээр нь эдийн засгийг авч явах гэж алдаж, түүнээсээ суралцаж буй нь бидний амьдралд хүндээр тусч байна. Нэг ёсондоо ажлын дадлага туршлага, мэргэжлийн мэдлэг боловсрол, наад захын энгийн логик сэтгэлгээ, хувь хүний ёс зүй дутмаг байгаагаас алдлаа.

**-Хүндэрсэн эдийн засгаа сэргээх арга байж л таараа. Нэн түрүүнд хийх ажил нь юу байх вэ?**

-Монголбанк, яамдын удирдлагуудыг мэргэжлийн хүмүүсээр удирдуул. Ингэж байж амьдралд ойр бодлого шийдвэр гарна. Эдийн засгийн хөгжлийн яамыг мэргэжлийн хүн удирдах ёстой. Бизнес, эдийн засаг итгэлцэл дээр тулгуурлаж явдаг. Ард түмний итгэлийг төр үгүй хийсэн. Зургаан жил ярьж байгаад зурсан гэрээгээ өнөөдрийн эрх баригчид түүн дотроо УИХ-ын дарга эсэргүүцэж эхэлсэн. Өмнөх Засгийн газрыг ажиллуулахгүй огцруулах талаар байнга ярьж байсан. "Чингис" бондыг гаргах нөхцөлийг өмнөх Засгийн газрууд бий болгосон. Өөрөөр хэлбэл, Монголд мөнгөө зээлдүүлэе гэсэн итгэлцэл бий болсон. Энэ боломжийн үзүүрээс атгасан одоогийн Засгийн газар үүнийг зөв ашиглаж чадсангүй. Ганц жишээ дурьдахад, төмөр замын санхүүжилтэд өгсөн 200 сая долларын талаар сураг сонсоход, зөвхөн шороо овоолсон байгаа юм. Бид хэдэн дарга нарын компаниудын том оврын машинаар говийнхоо хөрс шороог талхлаад, иргэд, мал амьтнаа тоос шороон дунд амьдруулсаар баялгаа Хятадын хил рүү машинаар зөөсөөр л байна. Төмөр зам тавих гээд хэрэлдсээр зургаан жил өнгөрлөө.

**-Төвбанк мөнгөний хатуу бодлого явуулбал өнөөгийн нөхцөл байдлаас гарна гэх хүмүүс ч байна.**

-Бодлого дээр илүү анхаарах ёстой. Мөнгөний хатуу бодлого явуулбал бид эдийн засгаа царцаачихна. Одоо

Төвбанк мөнгөө хумих гэж оролдож магадгүй. Энэ буруу. Хүндрэлээс гарах нэг горьдлого бол төмөр зам. Нэг үндэстэн, баг шиг урагш зүтгэж, Оюутолгойн гэрээний хоёрдугаар үе шатыг эхлүүлэх ёстой. ТЭЗҮ нь гурав хоногт танилцуулагдахгүй гэдэг нь тодорхой болчихлоо. Яагаад гэвэл, татварын маргаан таслах зөвлөл рүү "Рио Тинто" гомдол гаргасан. Тэгэхээр бид энэ оныг бүсээ чангалаад давахаас өөр аргагүй болж байна. Ирэх есдүгээр сарын 30-нд "Рио Тинто"-гийн санхүүжилтийн хоёр дахь хэсэг орж ирэх ёстой байсан. Дөрвөн тэрбум доллар. Одоо монголчуудаас баталгаа авахгүйгээр тэр мөнгийг оруулж ирэхгүй. Тэд манайд 1.2 тэрбум ам.долларын татвар төлчихөөд буй. Гэтэл нэг татварын байцаагч очоод танайх манайд 130 сая доллар төлөх ёстой гэснээс болоод тэд татварын маргаан таслах зөвлөлд хандсан байна. Ийм байхад дахин зээл авч, өөртөө лай хураахыг хэн ч хүсэхгүй.

**-Дарга, сайдгүй бүсээ чангалах ёстой гэх юм. Нэгэнт доллар орж ирэхгүй байхад хүндэрсэн эдийн засгийг яаж тордох юм бэ?**

-Шаварт унагаачихаад бүсээ чангалъя гэж дарга нар ярих нь буруу. Харин ч хариуцлагын асуудал яригдах ёстой. Нүүрсээ улс төрийн аргаар худалдах гэрээ байгуулах хэрэгтэй. Удахгүй Си Зинпинь айлчлах гэж байна. Зөв утгаад зөв гэрээнүүдээ зуруулах ёстой. Улиг болсон хийн хоолойн "үлгэр"-ийг хаях хэрэгтэй. Манайх төмөр замаа тавья, нүүрсийг маань таван жил тогтвортой худалдаж ав гэж санал болгон гэрээгээ шамдуул. "Саусгоби сэндс"-ээ танайх худалдаж аваад ажиллуул. Бид алдаа гаргажээ. Та нартаа мөнхийн найрсаг харилцаатай. Манай нүүрсийг ав" гэдэг талаар яриа хэлэлцээр хийх ёстой.

**-Манайд хариуцлагын тогтолцоо алдагдаад удаж байгаа. Зарим сайд алдаагаа ухамсарлаад суудлаасаа буухгүй болох нь УИХ дээр яригдаж буй сандал ширээний хэрүүлээс тодорхой харагдаж байна л даа. Ийм үед хариуцлага гэж ярих хэрэг байна уу?**

-Засгийн газар хариуцлагаа хүлээх ёстой. Асуудал эрхэлсэн сайд нартай хариуцлага ярих зайлшгүй шаардлагатай. Тэгэхгүйгээр цааш

явахгүй. Алдаа гаргаад байхад "За, одоо өнгөрсөн" гээд өнгөрүүлбэл дараа халааг нь авсан хүн алдаа гаргалаа ч толгойг нь илээд өнгөрдөг гэсэн сэтгэхүйтэйгээр ажиллана. Ингэж болохгүй. Төр цомхон байх ёстой. Хувийн хэвшлээр ажлаа хийлгэх хэрэгтэй. Хувийн хэвшил нь зохион байгуулалттай байх ёстой. Одооных шиг эрээвэр хураавар биш.

**-Та дээр улстөржилт их байна гэлээ. Танай намын бүлэг сөрөг хүчин гэдгээрээ ч тэгдэг үү зарим асуудалд хэт туйлширч, улстөржөөд байна уу даа гэж хардаг. Үүнийг та МАН-ын гишүүн бус иргэн хүний хувиар хэрхэн харж, үнэлэлт дүгнэлт өгөх вэ?**

-Улс төрчид улстөржих ёстой. Бизнес эрхлэгчид ажлаа хий. Би МАН-ын гишүүн гээд УИХ дахь бүлгийнхээ өмнөөс хариуцлага хүлээхгүй. Би УИХ-д сонгогдох гэж оролдсон, чадаагүй. Хувийн бизнесээ эрхлээд явж байна. Жирийн иргэд дөрвөн жилд нэг удаа улстөржихөөд бусад үед ажлаа хийдэг байх ёстой. Залуучууд дундаа тэрний энэний гэж хагаралдах нь яв ч сайнаар тусахгүй. Тэр үүднээс би Н.Алтанхуягийн Засгийн газрыг зөв ажил хийвэл дэмждэг. Буруу байдлаар нийгэм рүү дайрвал үзэл бодлоо илэрхийлдэг. Би Монгол Улсын иргэн. Энэ бол миний хамгийн түрүүнд өмсч яваа малгай. Дараа нь нам, бизнес яригдана. Тиймээс би Монгол Улсын эрх ашгийн төлөө нэн тэргүүнд дуугарах ёстой. Засгийн газар буруу зүйл их хийгээд байх юм. Үүнд би МАН-ын байр суурийг илэрхийлээд шүүмжлээд байгаа юм биш. Иргэнийхээ хувьд дуугарах үүрэгтэй. Тиймээс намайг намын малгайтайгаар харах хэрэггүй шүү дээ. Би эгэл жирийн иргэн.

**-Улс төрчид ултөржиж, бизнес эрхлэгчид ажлаа хийх ёстой гэж байна. Тэгэхээр бизнес эрхлэгчдийн хүлээгээд буй хууль эрх зүйн орчин батлагдахгүй хүлээлт үүсч, ажил аль аль талдаа гацах юм биш үү?**

-Сөрөг хүчнийг нөгөө талаас нь бас харах хэрэгтэй. Шинэ парламент бүрдсэний дараа жил гаруй бүлэггүй явуулсан. Одоо УИХ-ын нэг Байнгын хороо 20 орчим гишүүнтэй байхад 1-2 нь л манай намын төлөөлөл ▶

► байна. Энэ нь ардчилсан нийгмийн төлөөллийн зарчмыг алдагдуулсан. УИХ-ын гишүүдийн гуравны нэг нь ард иргэдээ төлөөлөөд парламентад сууж байхад Байнгын хороодын гишүүдийн намын харьяалал ийм тэнцвэргүй байна. Энэ нь МАН-ын гишүүдийн ард иргэддээ хүргэх дуу хоолойг боогдуулж байна гэж би боддог. Үүнд өширхөл бий болж байна. Үүнийг засч залруулах ёстой. УИХ-ын дарга ухамсартай хүний хувьд засах хэрэгтэй. Тэгэхгүй бол аюултай. Ардчиллыг боомилсон, түүний суурь үндсийг устгасан Монгол Улсыг буруу зам руу түлхсэн үйлдэл болж байна. “Давхар дээл”-ийг тайлуулна, сонирхлын зөрчилтэй байна гэж тухайн үедээ цээжээ дэлдэн батлуулж байсан хүмүүс өнөөдөр бүгдээрээ ярайтал сууж байна.

## Асуудалд нухацтай, болгоомжтой хандахгүй бол үндэсний эрх ашиг хөндөгдөнө

**-Засгийн газрын өрийн бодлогод та үнэлэлт дүгнэлт өгөөч. Өрийг ДНБ-ий 90 хувьд хүргэхээр хуулийн төсөл хэлэлцэж байна. Нөгөөтэйгүүр төсвөөс гадуурх мөнгүүд бас бий.**

-Зээл авч болно. Гэхдээ Оюутолгойг эргэлтэд оруулж, төмөр замаа шийдсэн байх ёстой. Монголбанк улс төрөөс хараат бус байж, мөнгөний бодлогоо дангаараа хэрэгжүүлэх хэрэгтэй. Ханш тогтворжсон байх ёстой. Учир нь, бид өнөөдөр зээл нэмж авахгүй байж илүү өрөнд орж буй юм шиг харагдаж байна. Валютын ханшийн өөрчлөлтөөс болоод улсын өр ДНБ-ий 60-аас дээш хувьд хүрсэн. Энэ асуудлуудыг шийдэхгүйгээр нэмж өр тавьж болохгүй. Ард иргэдэд төр “Хүний хөгжил сан”-гаар дамжуулан мөнгө өгнө гэж амласан нь өр мөн үү. Гаднын банкинд өгөх өрөө бүртгэхихээд иргэддээ олгох мөнгөө яагаад тооцдоггүй юм. Итгэлийг олж авч байж олон улсад унаад буй нэр хүндээ сэргээж авна. Үүний тулд шинэ хүмүүс гарч ирэх ёстой.

**-Шинэ хүн томилох нь дор хаяж хоёр жилийн дараах асуудал. Таны ярианаас ойрын 2-3 жилд эдийн**

**засаг сэргэхгүй нь гэж харж болох уу?**

-Сэргээж болно. “ЭЗЭН-100” хөтөлбөр зарлалчааад 100 үйлдвэр хувьчлан нэг нэгээр нь эзэн болоод сууна гэж болохгүй. Хувьчлалыг эдийн засаг хөгжиж, хүмүүс сонирхсон, мөнгөтэй байх үед явуулдаг болохоос үнэгүйдсэн хойно нь хувьчилдаггүй. Энэ бол төрийн өмч, Монголын ард түмэн, ирээдүй хойчийн маань өмч. Үүнийг 1996-2000 оны хооронд АН засаг барьж байх үедээ Төрийн өмчийн хороогоор наадсан шиг болгуулахыг өнөөдөр зөвшөөрч болохгүй.

“ Бидэнд сайн технологитой, дэлхийд тэргүүлээд байгаа компаниуд хэрэгтэй байна. Бодлогоо ч ийш нь чиглүүлэх ёстой. Тэгэхийн тулд монгол залуус хэлээрээ бус гар, хөлөөрөө ажилладаг болмоор байна. Хятадуудыг үзэн ядах хангалттай. Үзэн ядаад тэвчихгүй бол тэдний хийж буй ажлыг хий. Үүгээрээ эх орондоо хайртай, үнэнч гэдгээ харуул. Битгий хоосон цээжээ дэлд. ”

Оюутолгойг урагшлуулахгүйгээр эдийн засаг сэргэхэд хүнд. Улмаар манай улсын зээлжих зэрэглэл одоогийнхоосоо буурна. Гаднаас авсан бонд маань жанк /муу/ бонд болно. Жанк бондоор тоглодог сангууд манай өрийг худалдаж авна. Өөрөөр хэлбэл, нэг долларын өрийг 20 центээр худалдаж авна гэсэн үг. Олон улсын шүүхээс манай бүх гаднын хөрөнгийг царцаана. Тэгээд төлүүлж авна. Бид Африк, Аргентины зээлийн хямралын замаар ороод явж байна. Одоо үлдсэн ганц гарц бол улстөрийн шийдэл.

**-Хямралаас үүдэж олон аж ахуйн нэгж хаалгаа барьж байна. Халагдсан хүмүүс цалингаа**

**барьцаалан хэрэглээний болон орон сууцны зээл авсан нь банкны чанаргүй зээлд нөлөөлж эхэлсэн байх. Эдийн засгийн хүндрэл банкны салбарт хэрхэн тусч байна вэ?**

-Банкны салбарын чанаргүй зээлийн хэмжээ хоёр дахин нэмэгдсэн байсан. Эндээс ямар үзүүлэлт гарах нь ойлгомжтой биз дээ. Эдийн засгийн хүндрэлээс болоод өмнө нь хэвийн үйл ажиллагаа явуулж байсан үйлдвэрүүд түүхий эдээ авч чадахгүйд хүрч, улмаар бараа бүтээгдэхүүнээ зарж чадахаа больж байна. Хүмүүсийн худалдан авах чадвар буурлаа. Зарим нэг нь орлогогүй болж эхэллээ. Ихэнх нь банкны зээлтэй.

**-Гадаадын томоохон банкууд манайд төлөөлөгчийн газраа нээж байна. Тухайлбал, Bank of China. Энэ нь Монголын эдийн засаг тэр дундаа банкны салбарт ямар үр дүн авчрах вэ?**

-Хоёр талтай. Bank of China Монголд орж ирэх нь банк хоорондын өрсөлдөөнийг эрчимжүүлж, бидэнд агаар мэт хэрэгтэй байгаа гадаад валютын урсгалыг нэмэгдүүлэн бизнес эрхлэгчдэд таатай нөхцөл бий болгох замаар хүндрээд буй эдийн засагт сэргээш өгөх талтай. Манай банкуудын үйлчилгээ ч энэ нөлөөгөөр сайжирч, дунд хугацаанд үйл ажиллагаа нь чамбайрч, өрсөлдөх чадвар нь ч нэмэгдэх боломжтой. Харин дунд хугацаанд манай бүх өөдтэй, өнгөтэй бизнесүүдийг бага хүүтэй, их хэмжээний зээлээр тэтгэснээр бид нэг банкны барьцаанд бүхлээрээ орох эрсдэл бий. Өөрөөр хэлбэл, тэдний бидэнд үзүүлэх нөлөө, шахалт ихэсч, манай үндэсний гэх банкууд сайн харилцагчгүй мухардмал байдалд орж бүхлээрээ унах эрсдэл бий. Тэр үед тэдний зүгээс хэрэглэж болох нэг аюултай арга бол зөвхөн Хятадын оролцоотой, хятад эзэнтэй, хятад технологи ашигласан төслүүдийг дэмжиж, манай үндэсний гэх тодотголтой бизнесүүдийн өрсөлдөх чадварыг сулруулах. Улмаар үгүй хийх бодлого барих боломж үүсэхийг үгүйсгэхгүй. Иймд бид энэ асуудалд туйлын нухацтай, болгоомжтой хандах нь үндэсний эрх ашигт нийцнэ. Би энд заавал хориг тавь ►

▶ гээгүй. Бид зөвшөөрөл өгвөл эдгээр хүчин зүйлсийг тооцоолж, анхнаасаа алсаа харсан зөв хязгаарлалт, нөхцөл бүхий, нарийн хяналтын дор үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгон ажиллуулж болно. Манайх жижиг эдийн засагтай орон. Тэгсэн хэр нь дэлхийн хамгийн том хүчтэй хоёр гүрний дунд хавчигдсан өвөрмөц онцлогоо хэзээ ч мартаж болохгүй. Хараат бус бодлого хэрэгжүүлэх арга зам нь эдийн засгаа төрөлжүүлэх, бэхжүүлэх, гаднын хөрөнгө оруулалтыг маш ихээр татах явдал юм. Хятадад банкны салбар нээх эрх өгөх гэж буй бол ОХУ, АНУ-д ч өгөх хэрэгтэй. Үгүй бол гурван саяуулаа тохирох ёстой.

#### -Юу гэж?

-Аль нэг банкаа бүгдээрээ худалдаж авъя. Өөрөөр хэлбэл, гурван сая иргэн бүр 100 мянган төгрөг гаргаад бүгд хувьцаатай болж, ард түмний банк болгочихъё. Тэндээ хадгаламжуудаа нээе. Хятад банкаас зээл авч бизнесээ явуулж, ашиг олчихоод өөрсдийнхөө банкинд хадгалуулъя.

### Эх орончид “Би эх оронч” гэж цагаан хоолойгоор зарладаггүй

**-Сүүлийн үед хаа сайгүй хөгжил гэж их ярих болжээ. Та хөгжил гэдгийг юу гэж ойлгодог вэ?**

-Би өмнөх Засгийн газрын үед дэд сайд байхдаа эдийн засаг төдөн хувиар өслөө, инфляцийг ингэж барьж байна, цалин тэтгэвэр тэтгэмжийг нэмэгдүүллээ, Маршал, Тэрэлжийн гүүрийг заслаа гэж ярьж байсан. Тэр үед залуус “Амьдралд мэдрэгдэхгүй байна” гэдэг байсан. Төд удалгүй цалин хөлс нэмэгдэж, байшин барилга баригдан гадаад дотоодын хөрөнгийн урсгал сайжирсан. Энэ бол хөгжлийн илрэл байв. Үүнийг зарим залуу МАН-д дургүйдээ ч болсон уу харахыг хүсэхгүй байсан. Гэхдээ энэ бол хөгжил байсан. Эдийн засаг өсч байгааг хүн бүхэн мэдэрч байв. Сайн муу ч бай оюутнууд 70 мянган төгрөг авдаг болсон. Харин энэ Засгийн газар гараагаа сайн хийсэн. Өмнөх Засгийн газрын эхлүүлсэн “Салхит”-ын цахилгаан станц, “Энержи ресурс”-ийн зам, Нарны гүүр зэрэг ажлын туузыг очиж хайчилсан. Бид Хөгжлийн банкны

дансанд 600 сая ам.доллар үлдээгээд явсан. Харамсалтай нь, өнгөрсөн хоёр жилийг үр бүтээл муутай өнгөрүүлчихлээ. Хий улстөржлөө. Ардчиллынхаа үнэт зүйлийг бүгдийг нь умартаж эрх мэдлийн төлөө улайрч дайрлаа. Албан тушаал авах гэсэн фракцуудын хоорондын тэмцэл сайн үр дүн авчирсангүй. Оюутолгойг гацаасан явдал нь манайхан гүйж байгаа хөл рүүгээ буу барьж байгаад буудсантай адил зүйл болсон. Өөрөөр хэлбэл, хөгжлөө зогсоосон. Улс хөгжилтэй байхын тулд иргэд нь боловсролтой байх ёстой. Хөгжил эдийн засгийг өрсөлдөх чадвартай болгодог. Нөгөөтэйгүүр өрсөлдөх чадвартай болж байж бид хөгжил рүү тэмүүлнэ. Өрсөлдөх чадвартай байна гэдэг богино хугацаанд чанартайгаар ихийг бүтээж, үнэтэйгээр зарах явдал юм. Ингэхийн тулд бидэнд боловсон хүчин, хөрөнгө мөнгө, дэд бүтэц, худалдан авагч зах зээл, мэргэн санаа хэрэгтэй. Энэ бүхэн нийлж байж баялаг бүтнэ.

Италччууд яагаад арьсан цүнхээ 2000 доллараар зарж байхад Монголд үйлдвэрлэсэн арьсан цүнх 30 мянган төгрөгийн үнэтэй байна вэ. Дизайн, өнгө үзэмж, чанар, брэнд, технологи нөлөөлж байна шүү дээ. Тэд арьс ширний зориулалтаар ашиглах малыг тусгай зориулалтын байранд байлгаж, хооллож, тэжээж, бордож, зориулалтын аргаар нь нядалж байж тэр арьсыг гаргаж авч байна. Нарийн боловсруулалтын технологи, чадварлаг боловсон хүчнийг ажиллуулж байна.

**-Ийм болохын тулд Монгол залуус боловсролтой байх ёстой. Гэтэл манайд боловсролын чанар сайн биш.**

-Боловсролтой болохын тулд бидэнд мөнгө хэрэгтэй. Мөнгөтэй болохын тулд бид төмөр зам тавих ёстой. Хойд хөрш рүү бид нүүрс зөөхгүй. Тэд манайхаас нүүрс авах ч үгүй. Хятадууд манай нүүрсийг авч магадгүй. Тэнэг, явцуу, мэдлэг боловсролгүй, хоосон популист ярианд орж, Нисэхийн замыг барьж буй хятадуудыг очиж зодно гэж зарим залуу ярьж буй нь утгагүй зүйл. Тийм л сүрхий юм бол өөрсдөө хүрз, жоотуугаа бариад тэр замаа барь. Гэхдээ хятадуудыг олноор оруулж ирэхийг би буруутгадаг. Ялангуяа хар

ажилчдыг. Харин өндөр технологи нэвтрүүлж буй Хятадын компаниудыг оруулж ирэх ёстой. Солонгос ч адил. Хоолны газар ажиллуулдаг солонгосчууд одоо хангалттай. Бидэнд сайн технологитой, дэлхийд тэргүүлээд байгаа компаниуд хэрэгтэй байна. Бодлогоо ч ийш нь чиглүүлэх ёстой. Тэгэхийн тулд монгол залуус хэлээрээ бус гар, хөлөөрөө ажилладаг болмоор байна. Хятадуудыг үзэн ядах хангалттай. Үзэн ядаад тэвчихгүй бол тэдний хийж буй ажлыг хий. Үүгээрээ эх орондоо хайртай, үнэнч гэдгээ харуул. Битгий хоосон цээжээ дэлд.

**-Эх оронч үзэл гэдгийг та энгийнээр тайлбарлахгүй юу?**

-АПУ компани сүүний үйлдвэр нээлээ. Энэ бол эх оронч хүмүүс. Шинэ технологи оруулж ирэн хүмүүс сурган ажиллуулж, олон зуун хүнийг ажлын байраар хангаж байна. “Салхит”-ын цахилгаан станцыг эх оронч хүмүүс барьсан. “Энержи ресурс”-ийн Өмнөговьд барьсан хотхон эх оронч хүний хийсэн ажил. Тэнд барьсан цахилгаан станц эх орончдын бүтээл. Эрдэнэтийг эх орончид бүтээн байгуулсан. Эх орончид би эх оронч гэж цагаан хоолойгоор зарладаггүй. Ард түмний өмнөөс гэж хоолойгоо зангируулж, цээжээ дэлдэж, талбай дээр хүчирхийлэлд уриалж зогсдоггүй. Эх орончид эх орондоо хайртай учраас бүтээн байгуулахын тулд байшин, үйлдвэр барьж олон мянган хүнийг ажлын байраар хангаад явдаг. Сургууль байгуулж, хүүхдүүдийг сурган хүмүүжүүлж, гадаад багш авчирч ажиллуулдаг. Ар гэр амьдралаа авч явах гэж гэрээгээр ирж энд ажиллаж байгаа ядруухан хятадыг балбачихаад би эх оронч гэж бодож ярих нь утгагүй. Энэ бол гэмт хэрэг. Нөгөөтэйгүүр гадныхныг гудамжинд барьж аваад зодож байгаа залууст хэлэхэд, энэ бол эх орноосоо урваж буй хэрэг. Монголын тусгаар тогтнол аюулгүй байдалд шууд заналхийлсэн үйлдэл гэж би хардаг. Монголчуудыг Сөүлийн “Инчон”-ы нисэх онгоцны буудал дээр буухад солонгосчууд барьж аваад зодоод байвал ямар вэ. Үүнтэй л адил ойлголт.

**-Ярилцсанд баярлалаа. Таны ажилд амжилт хүсье. ■**

## ҮЛ ХӨДЛӨХ

# ГАЗАР ӨМЧЛҮҮЛЭХЭД БЭЛЭН ҮҮ

Нийслэлийн иргэдэд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 52 байршилд газар өмчлүүлэхээр болсон. Өнгөрсөн жил ийм шийдвэр гарсан ч өнөөг хүртэл ажил болон хэрэгжээгүй, иргэд хүлээсээр байгаа. Ямартай ч газар өмчлөх сонирхолтой иргэд цахим хэлбэрээр хүсэлтээ гаргахаар болсон. Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар дээрх 52 байршлаас эхний 20-д, зуслангийн таван хэсгийн зургийг баталгаажуулжээ. Эдгээр газрыг хаягжуулан зам талбай тавих, хаана нь ногоон байгууламж байгуулах вэ гэдгийг хэсэгчилсэн төлөвлөгөө гаргах аж. Энэ сард иргэдэд хэрхэн газар өмчлөх, цахимаар яаж бүртгүүлэх талаар сурталчлан таниулах юм байна. Үүний дараа буюу наймдугаар сараас дээрх байршлуудад газар өмчлүүлэх аж.

## Эхний ээлжинд олгох газрын байршлыг танилцуулж байна

- БЗД, 20 дугаар хороо, Их цуурайн ам-71 га
- БЗД, 20 дугаар хороо, Бага цуурайн ам-49 га
- БЗД, 9, 24 дүгээр хороо, Баруун цагаан давааны урд ам-25 га
- БЗД, 20 дугаар хороо, Цагдуултын ам-87 га
- ХУД, 12, 13 дугаар хороо, Эрдэнэтолгой-155 га
- СХД, 32 дугаар хороонд Эмээлт уулын баруун хоолой, 565 га
- СХД, 32 дугаар хороонд Эмээлтийн дөрөлж, 180 га
- СХД, 32 дугаар хороо, Шар хөв-76 га
- СХД, 32 дугаар хороо, Түрүүний хөндий-227 га
- СХД, 22 дугаар хороо, Тахилтын хөндий-184 га
- СХД, 21 дүгээр хороо, Долоон худгийн хөндий-71 га
- СХД, 21 дүгээр хороо, Соёондын ам-517 га
- СХД, 21 дүгээр хороо, Өндөр хаан уул-69 га
- СХД, 21 дүгээр хороо, Цагаан чулуут-576 га
- БЗД, 20 дугаар хороо, Хожуулын ам-166 га
- СБД, 16 дугаар хороо, Тоосгоны 1-р хэсэг-64 га
- СБД, 16 дугаар хороо, Тоосгоны 2-р хэсэг-64 га
- БНД, 4 дүгээр хороо, Тариан булгийн 1-р хэсэг-526 га
- БНД, 4 дүгээр хороо, Тариан булгийн 2-р хэсэг-376 га
- Багахангай дүүргийн 2 дугаар хороонд Бор үзүүр, 160 га

## Зуслангийн батлагдсан ерөнхий төлөвлөгөөний дагуу хийсэн эхний таван байршил

- СБД, 15 дугаар хороо, Ар хустай
- СБД, 20 дугаар хороо, Цолмон
- СБД, 20 дугаар хороо, Цээнэ
- ЧД, 19 дүгээр хороо, Жигжид
- ЧД, 19 дүгээр хороо, Яргайт

Байршлын танилцуулга
Өргөдөл бөглөх

Баталгаажуулах код:  Өргөдөл шууд бөглөх

**Тайлбар!** Анх удаа өргөдөл бөглөж байгаа бол эхлээд доорх өргөдлийг бөглөж илгээснээр танд баталгаажуулах код ирэх болно. Мөн өмнө нь өргөдөл илгээгээд баталгаажуулах код авсан бөгөөд газар өмчилж амжаагүй байгаа бол та тухайн кодоороо дээрх сонгосон байршилд өргөдөл дахин бөглөхгүйгээр хүсэлт илгээх боломжтой.

**Өргөдөл гаргагчийн мэдээлэл**

\*Хүсэлт гаргагчийн төрөл:  ▼

**Өөрөө /хүсэлт гаргагч/** Энэхүү өргөдлийг шинээр газар өмчилж авахыг хүссэн иргэн гаргана.

**Итгэмжлэгдсэн төлөөлөгч & Төлөөлүүлэгч**

Өмнө нь гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар дундаа хамтран өмчилсэн бөгөөд тухайн газрын өмчлөх эрхийг гэрээний үндсэн дээр гэр бүлийн нэг гишүүнд шилжүүлсэн, иргэний эрх зүйн бүрэн чадамжтай иргэн шинээр газар өмчилж авахыг хүсвэл энэхүү өргөдлийг гаргана.

## ИРГЭНИЙ АГААРЫН ТЭЭВЭР

# “ХИЛ ХЯЗГААРГҮЙ” САЛБАРЫН ДАЛАВЧ


## Б.ЭНХЦЭЦЭГ

Өндөр хөгжсөн орнуудад хувийн онгоц хөлөглөн ийш тийш агаараар холжих нь баян хүний аархал уу эсвэл зүгээр л өдөр тутмын хэрэглээ юу. Эдгээр оронд дунджаар 50 цагийн нислэгийн дадлага хийж, 20 цагийн онолын хичээл бүхий сургалтад суусан хувьдаа нислэг үйлдэх эрхтэй хувийн нисгэгчид хэдэн зуун мянгаараа бий. Автозамын хөдөлгөөний дүрмээр бол В ангиллын жолооч л гэсэн үг. Ялгаа нь нэг нь агаараар, нөгөө нь газраар зорчдог.

Агаарын тээвэр болон цэргийн нисэх хүчнээс бусад бүх нислэгийг Ерөнхий зориулалтын нисэхийн (ЕЗН) салбарт багтаан авч үздэг. Тодруулбал үүнд бизнесийн, хөдөө аж ахуйн, хувийн болон чөлөөт цаг, спорт мөн сургалтын зэрэг нислэгүүд багтана.

Тэгвэл энэхүү ЕЗН Монголд огт хөгжөөгүй гэхгүй ч хөгжлийн анхан шатандаа гацсаар удсан. Олон улсын туршлагад Нисэхийн салбарт ЕЗН нь эхэлж хөгждөг бол манай улсын хувьд 360 градус эсрэгээрээ. Тодруулбал, тэртээ 50 гаруй жилийн өмнө сансарт хүнээ нисгэсэн Азийн хоёр дахь орон мөртлөө, ерөнхий зориулалтын нисэх нь өнөөдөр хөгжлийн хувьд балчир хэвээр. Өөрөөр хэлбэл уруугаа харсан пирамид загвартай. Гэвч тус салбар Социализмын үед сууриа тавьж, хурдацтай өссөн ч ардчилал гарснаар урагшлах бус ухарсан байдаг.

Тэртээ ЗХУ-аас Монгол Улсад бэлэглэсэн ачаа тээврийн “Ю-13” онгоц Монголд анх газардсан 1925 оны тавдугаар сарын 25-ныг Монголд нисэх хүчин байгуулагдсан өдөр гэж зүй ёсоор тооцдог. Хожим нь 1946 онд дээд зэрэглэлийн долоон онгоц,



нэг “По-2” онгоцтой Иргэний агаарын тээврийн тасаг байгуулагдаж Дундговь, Сүхбаатар аймаг, Сайншанд, Өндөрхаан чиглэлд дотоодын иргэний агаарын тээврийн үйлчилгээ үзүүлж эхэлсэн байдаг.

Одоогоос 60 жилийн өмнө буюу 1958 оны байдлаар Монгол Улс нийт 21 онгоцтой болсон ба 11605 зорчигч, 363700 кг ачаа, шуудан тээвэрлэдэг болоод байж. Харин 1970 он гэхэд Монголын иргэний агаарын тээврийн МИАТ компани аймаг, сум, нэгдлийн төв зэрэг дотоодын нислэгийн 130 газарт буюу нийт нислэг үйлддэг газрынхаа 80 хувьд үйлчилгээгээ үзүүлдэг болсон. Тиймээс нийт 21 аймгийн 17 нь өнөөдөр ч онгоц хөөрөх, буух зурвастай, хяналтын цамхагтай байдаг бөгөөд үүний зургаа нь хатуу хучилт бүхий замтай нь бидэнд одоо ч хөгжлийн суурь бий гэсэн үг.

Одоогийн байдлаар манай улсад Ерөнхий зориулалтын нислэгт тэнцэх, энэ ангилалд багтах 10 хүрэхгүй агаарын хөлөг байгаа ч өргөн уудам

нутагтай, дэд бүтэц сул хөгжсөн, эдийн засаг эрчимтэй өсч буй энэ үед уг тоо хэд дахин ч өсөх бололцоо бий гэж салбарынхан үзэж байна.

Хуваарьт нислэг хийдэг агаарын тээврийн компаниуд зах зээлийн 99 хувийг хуваарьт бус нислэг хийдэг өөрөөр хэлбэл ерөнхийн зориулалтын нисэхийн компаниуд бүх чиглэлд зах зээлийн нэгхэн хувийг эзэлж байна.

Олон улс тэр дундаа бидний харьяалагддаг Ази энэ салбарт өндөр ач холбогдол өгч байна.

Өнгөрсөн жилийн есдүгээр сард Ази Номхон далайн бүс нутгийн 21 улсын Тээврийн сайд цуглаж, энэ бүс нутагт бизнесийн нислэгийн үйл ажиллагааны үндсэн зарчмуудыг баталж, дээрх улсуудын хооронд чөлөөтэй нисэхээр болгосон. Бизнесийн агаарын хөлгийн тээвэрлэлтийн зах зээлд эзлэх Ази Номхон далайн бүс нутгийн хувь хэмжээ 2007-2012 оны хооронд хоёр дахин нэмсэнийг Ерөнхий зориулалтын нисэхийн 2014 оны тайланд дурьджээ. ▶

► “GAMA” нислэгийн компанийн захирал Пит Банс “Бизнесийн нислэг бол зөвхөн өндөр өгөөжтэй бизнесийн арга хэрэгсэл бус тухай улсуудын хувьд эдийн засаг, бүс нутгийн хөгжлийн хурдасгуур болж буйг тус бүс нутаг дахь ерөнхий зориулалтын нисэхийн салбарын огцом өсөлт харуулж байна” хэмээв.

Үүнээс гадна манай улсын хоёр хөрш ч тус салбарт хүчээ зузаатгаж, хөгжлийн хурдаа нэмэх бодлого барьж эхэлжээ. Тухайлбал ОХУ-ын өнгөрсөн оны сүүлчээр ЕЗН ийн чиглэлд баримтлах үйл ажиллагааны төлөвлөгөө баталсан бол Хятадад тус салбарын тэсрэлт явагдаж байгаа бөгөөд агаарын хөлгийн супермаркет Бээжин хотод нээгдээд байна.

ЕЗН нь иргэний агаарын тээврийн нэг төрөлд хамаардаг ч баримталж буй бодлого чиглэлээс үргэлж гадуурхагдаж, гадна үлддэг гэх. Хэдийгээр Иргэний нисэхийн удирдлагын тогтолцоо улам бүр сайжирсаар байгаа ч өнөөгийн хууль тогтоомж нь удирдлагад шаардлагатай өөрчлөлт хийхэд дэмжлэг үзүүлж чадахгүй байгааг шүүмжлэх хувийн хэвшил олон.

Одоогийн мөрдөж байгаа Шинэ Зеландаас шууд хуулсан 2001 оны Улсын нисэх, Иргэний нисэхийн хууль, дүрэм нь нийтлэг бүх асуудлыг нэгтгэн зохицуулах боломжгүй байгаагаас агаарын цэргийн хүчин болон иргэний агаарын тээврийн удирдлага ЕЗН-т шаардлагатай байгаа жигд үйл ажиллагааг зохицуулах, удирдан хянах боломжгүй байгаа аж. Зөвхөн улсаас ЕЗН-ийн онцлогт тохирсон хуулийн заалт, холбогдох багц дүрмийг шинэчлэн баталж байж, Ерөнхий зориулалтын нислэгийн хэрэглээнд тулгарч буй асуудал шийдэгдэнэ гэж салбарынхан үзэж байна.

## Арилжааны нислэг ба салбарын хөгжил

Манай улсад өнөөдрийн байдлаар энэ чиглэлээр арилжааны нислэг үйлддэг зургаан компани байдаг бөгөөд онгоцны төрлөөс хамааран түрээсийн үнэ нэг цагийн 1500-4000 ам.доллар байдаг. Энэ нь олон улстай харьцуулахад 30 хувиар өндөр дүн ч ирээдүйд жижиг онгоцнуудын хувьд 300-400 ам.доллар болох боломж

бий гэж салбарынхан үзэж байна. Хувьдаа нисгэгч болохыг хүссэн иргэдэд зориулсан сургалтыг дээрх компаниудын зарим нь явуулдаг. Хувийн онгоц гэхээр монголчуудын санаанд нэг л ойр бууж өгдөггүй тал бий. Тэгвэл хувийн хэрэгцээнд жижиг онгоц худалдан авахад төрлөөс хамааран 50 мянган ам.доллараас үнэ нь эхэлдэг. Яг үнэндээ өнөөх том жийп машинуудаас ч хямд болж таарч байна.

“Монголд цаг агаарын нөхцөл амаргүй ч бага оврын агаарын хөлгийн хувьд нисэх боломжтой өдрийн тоо 250 гэгддэг бөгөөд жилд дунджаар 500-700 цаг ниснэ гэж тооцбол жилдээ нэг онгоц 200 мянган ам.долларын

“ Дэлхий даяар ЕЗН салбарт 360 мянган агаарын хөлөг үйлчилж, 700 мянга гаруй нисгэгч үүрэг гүйцэтгэж байна. Томоохон газар нутагтай, хот суурингууд нь хоорондоо хол зайтай, хүн ам нь сийрэг таруу байршин амьдардаг улсуудад тус салбарын хэрэгцээ хамгийн их гардаг. ”

ашиг өгөх боломжтой” гэж Монголын Ерөнхий зориулалтын Агаарын тээврийн холбооны ерөнхийлөгч Х.Бүрэн-Эрдэнэ хэлж байгаа юм. Тэрбээр мөн хэлэхдээ төрийн оролцоо, санхүүжилтгүй харин хувийн хэвшил, иргэдийн оролцоотойгоор энэ салбарыг босгоод ирэх боломж бий. Үүнийг хийхэд салбарын хуулинд хувийн нисгэгчдийн зохицуулалтыг тодорхой болгох ёстой бөгөөд хуваарьт нислэг үйлддэг том агаарын тээвэрлэгчийг бага оврын агаарын хөлгөөр нислэг үйлдэх Ерөнхий зориулалтын нислэгийн эрх зүйн зохицуулалтаас салгах нь зүйтэйг хэлж байлаа. Нисэхийн сургалт, онгоц, нислэгийн хөөрөх, буурах зурвас гэх



мэт бусад хүчин зүйлс бүгд бэлэн харин хууль эрх зүйн орчин, хувийн нисгэгчид л дутаж буй.

Хөгжингүй орнуудад онгоцыг хувийн хэрэгцээнд ашиглах эс бөгөөс арилжааны чиглэлээр ашиглах гэдгийг ялгаж салгасан байдаг. Тиймээс тодорхой шалгууруудыг хангасны үндсэн дээр хуваарьт бус захиалгат нислэг үйлдэх эрхтэй бизнес эрхлэгч, арилжааны нисгэгч болдог. Энэ бол Агаарын тээврийн том оврын онгоцууд бүхий компаниудын хүрч чадахгүй хэсэгт хүрч, гүйцэлдүүлж чадахгүй үйлчилгээг үзүүлж чадах нэг талаас бизнесийн нөгөө талаас иргэдийн хэрэгцээнд тулгуурласан салбарын томоохон орон зай.

Дэлхий даяар ЕЗН салбарт 360 мянган агаарын хөлөг үйлчилж, 700 мянга гаруй нисгэгч үүрэг гүйцэтгэж байна. Тус салбарт АНУ, Канад, Шинэ Зеланд, Бразиль, Англи зэрэг орон тэргүүлэгч байр суурийг эзэлдэг. Томоохон газар нутагтай, хот суурингууд нь хоорондоо хол зайтай, хүн ам нь сийрэг таруу байршин амьдардаг улсуудад тус салбарын хэрэгцээ хамгийн их гардаг. Тиймээс ч дээрх улсуудад илүү өндөр хөгжсөн байдаг. Эдгээр улсад хувь хүн онгоц эзэмшиж, хувьдаа ашиглах нь яг л автомашин өмчилж, жолоодох эрхтэй В ангиллын жолоочтой ижил. Гэвч арилжааны буюу төлбөртэй нислэг үйлдэхэд шаардлага арай өөр.

Эдгээр улсаас салбартаа акул нь АНУ бөгөөд тус улсад зах зээл нь биеэ ►



Хөвсгөл аймаг, Цагаан-Үүр сум

▶ даасан салбар. Тус улсын кинонууд дээр онгоц хөлөглөн нааш, цааш холхих дүр зураг олонтаа гардаг нь хэтрүүлэг гэхээс илүүтэй бодит байдал. Америкт дэлхий нийт агаарын хөлгийн гуравны хоёр буюу 209 мянга нь байдаг. Холбооны нисэхийн удирдах газрын судалгаагаар тус улсын ЕЗН-ийн салбар нь эдийн засагтаа жил бүр 150 тэрбум ам.долларыг оруулж, 1.2 сая ажлын байр бий болгодог байна. Түүнчлэн агаарын замын урсгалын 75.6 хувийг ЕЗН-ийн агаарын хөлгүүд эзэлж, салбарын хууль дүрмийн 37 хувь нь энэ хэсэгт зориулагдсан байдаг байна. Жилд нийт 25 сая нислэгийн цаг бүртгэгдсэний гуравны хоёрыг бизнесийн зорилгын нислэг эзэлдэг гэсэн тооцоо бий.

Нисэхийн салбар хилийн дээсээр зах зээлээ хязгаарлуулдаггүй. Тиймээс өнөөдөр манай компаниуд дотоодын зах зээлээсээ хальж, гаднын улс орнуудад захиалгат нислэг үйлдэх тендэрт мөн оролцож, ажлын цар хүрээгээ өргөтгөж буй. Энэ салбарын хөгжлийг дагаад аймаг сум хоорондын нислэг сэргэж, шуудан тээвэр, эрэн хайх, авран хамгаалах, аялал жуулчлал, түргэн тусламж, ашигт малтмал, геологи, геохими, хор цацах гэх мэт олон төрлийн нислэгийг хийх боломж бий, мөн шаардлага нь ч бий. Энэ төрлийн нислэгүүдийг ч цөөн тоогоор хийдэг ч зах зээлээ тэлэх шаардлага байгааг компаниудын эзэд хэлж байна.

## Агаарын ажилгүйдүүд багтах орон зай

Өнөөдөр жил бүр хэдэн арван нисгэгч АНУ, Канад тэргүүтэй нисэхийн салбар өндөр хөгжсөн газар сургууль төгсөн ирж буй. Тэд ирсэн даруйдаа ажилд ордог гэвэл худлаа. Товчхондоо тэд төгссөн мэргэжлийнхээ хувьд ажилгүйдүүдийн эгнээнд элсдэг.

Тэгвэл энэ олон ажилгүй нисгэгчид мөн тус салбарын дагалдах мэргэжилтнүүдийг сургуулийн ширээнээс ховхронгуут ажилтай болгож, туршлага хуримтлуулахад тусладаг салбар бол Ерөнхий зориулалтын нисэх. Бусад оронд ч ийм л байдаг. “Олон улсын нийтлэг жишгээр залуу нисгэгчдийн нислэгийн цаг болон туршлагыг ЕЗН-ийн салбараар дамжуулан хуримтлуулдаг нь чанартай боловсон хүчин бэлтгэх шилэгдмэл арга” гэж Залуу нисгэгчдийн холбооны тэргүүн, нисгэгч Э.Энхзориг хэллээ. Гаднын улс орнуудад нисгэгч бэлдэхэд 80-90 мянган ам.доллар байдаг. Гэтэл нэг хүн сургах энэ мөнгөөр жижиг оврын онгоц худалдан авч болно. Улмаар дотооддоо нисгэгч бэлтгэх суурь баазыг хөгжүүлэх боломж бий. Манайх 1990 оны дунд үе хүртэл АН-2 нисэх онгоцоор өнөөгийн ахмад гавьяат, нисгэгчдийг бэлтгэдэг байсан байдаг.

“Өнөөдөр нисэхийн салбарт үүссэн ажлын байрны хомсдолоос үүдэн нисгэгчдийн үнэлэмж үгүйрэн, ажлын байр хомсдож, төрийн сангаас олон зуун мянган ам.доллараар бэлтгэсэн нарийн мэргэжлийн боловсон хүчин өнөөдөр зэвэрч байна. Үүнийг дагаад хувийн авиа компаниуд нисгэгч нарын үнэлэмжийг бууруулж, цалинг доогуур барьж, хөдөлмөрийн гэрээний хувьд барьцаанд оруулах хандлагатай болсон” хэмээн Э.Энхзориг хэлсэн.

Монголын залуу нисгэгчдийн холбооны нэр бүхий гишүүд төрийн зардлаар амжилттай суралцаж, ИНЕГ-ын томилолтоор авиа компаниудад ажилтай болсон ч одоог хүртэл удаан хугацаагаар газрын үйлчилгээний ажил хийж байна. Энэ нь өндөр үнээр бэлтгэгддэг нисэхийн нарийн мэргэжлийн боловсон хүчний хувьд ур чадвар болон нислэгийн үйл ажиллагаанаас төсөөрч дахин мэргэжлийн давтан сургалтанд сурахуйц хэмжээнд очиход хүргэж буй. Энэ мэт байдал нь Иргэний нисэхийн салбарт удаан үргэлжилвэл 90 жилийн түүхт нисэхийн салбарын хойч үе болсон нисгэгчид туршлагагүй, чадваргүй болохын зэрэгцээ олон улсын зах зээлд гологдох нэг шалтгаан болж мэдэх. Мөн ойрын ирээдүйд нисэхийн болон нислэгийн аюулгүй байдалд шууд нөлөөлөх хүчин зүйл болж мэдэх.

Хэрвээ Монголд ЕЗН хөгжсөн байсан бол “Изинис” компанийн дампуурлаас болж ажилгүй болсон 200 гаруй хүн ЕЗН-ийн зах зээлд шингэх боломж байх байлаа. Даанч бид хөгжлийн урвуу хэлбэрээр яваа юм хойно шингээх зах зээл нь байхгүй. Тиймээс цөөн толгой авиа компаниуд нь өрөвдөхөөс хэтэрсэнгүй.

Ирэх жилүүдэд эдийн засгийн өндөр өсөлт хэвээр хадгалагдаж, хөдөө орон нутгийн хөгжил эрчимжвэл Ерөнхий зориулалтын нислэгийн хувьд хөгжлийн хурдацтай үе байх болно гэсэн хүлээлт салбарынханд байна. Энэ оны сүүлээр салбарын зарим асуудлыг тодорхой болгож, боломжуудыг нээж өгсөн шинэ хуулийн төслийг өргөн барина. Хэрэв тус хууль дэмжигдвэл Агаарын тээврийн салбарт шинэ үе, Монголын эдийн засагт “далавч” нь болох учиртай. Товчхондоо Би, Та нисгэгч байж болдог болно. ■

## НОМЫН БУЛАН

## ХҮМҮҮН ЦАДИГ

## Э.ЗОРИГТ

... Арван дөрөвтэй хүүгийн ажлын хөлс, сарын нийлбэр дүнгээрээ нэлээд их мөнгө болчихно. Тэр цагийн ханшаар мянга гаран төгрөгийн шагнал бичигдчихсэн байх энүүхэнд. Улсыг Аюулаас хамгаалахын байцаагч, ахлах офицер хүний сарын цалин 350 орчим төгрөг, малын зах дээр нас гүйцсэн эр хонь 30 төгрөгийн ханштай байсан гээд бодохоор тэр цагтаа шаггүй их цалин! 33 бүдүүн эр хонь авчих мөнгийг сарын шагналдаа авна гээд ойролцоогоор бодохоор өнөөгийн ханшаар зургаан сая 600 мянган төгрөг авсантай тэнцэх нь! Гэтэл үйлдвэрийн захиргаа Доржсүрэнг хүүхэд гээд их мөнгө өгөхгүй. Жаахан хүүхдэд тийм их цалин өгчих нь тэр үеийн зарчимд нийцэхгүй байсан хэрэг. Тэр ч бүү хэл, шагнал цалинг нь комбинатын захиргааны шийдвэрээр хаачихсан байж.

-Жаахан хүүхдэд ийм их мөнгө өгч яаж болох вэ. Хар багаас нь мөнгөний шуналтан болгож эвдэх нь..! гэж хурал дээрээ хэлэлцсэн нь тэр. Харин энэ бүхэн еврей удамтай, орос мэргэжилтэн Рачуновт таалагдсангүй. Тэр хүн арван дөрөвхөн настай слесарьтаа их сайн байсан учраас захиргаа руу гүйж очив.

-Та нарт ичих нүүр алга уу? Жаахан хүүхдийн шагнал цалинг яагаад хаачихаж байгаа юм бэ? Насанд хүрээгүй, юугаа ч мэдэхгүй хүүхдийг луйвардсантай ялгаа алга! гэж уурлан бөөн хэл ам хийлээ. Дарга нар өнөөх тайлбараа хэлж, ятгаж сэнхрүүлэх гэж оролдсон ч, еврей эр бууж өгөлгүй үзэлцээр байгаад хүүгийн шагнал цалинг хагас дутуу ч болов олгуулах шийд гаргуулж байж. Тэр үед орос мэргэжилтэн гэдэг их эрх дархтай, эвэртэн туурайтнуудыг айлгаж чаддаг хүмүүс байсан хэрэг... Энэ бол зохиолч А.Амарсайханы “Арван дөрөвтэй том хүн” зохиолын хэсэг.



Шог зураач, зохиолч, сэтгүүлч А.Амарсайхан “Хүмүүн цадиг” цувралын эхний номоо гаргалаа

хүн” зохиолын хэсэг.

Тэртээ 1930-аад онд долоон настайдаа гэрийнхэнтэйгээ хамт Булган аймгаас үхэр тэргээр нийслэл хүрээг зорьсон жаалхан хүү Г.Доржсүрэнгийн түүхээр уг ном эхэлнэ. Зохиолын эхэн хэсэгт хот гэх их айлыг зорьж ирсэн жаал унадаг дугуй гэж мэдэхгүй айн уйлж, ээжийнхээ мөөмийг үлгэсэн балчирхан хүүгийн бор өдрүүдээс Комбинатын бага сургууль, Уран дарханы сургууль дүүргэж байгаагаар үйл явдал өрнөж байна. Харин номын өрнөл хэсэгт Г.Доржсүрэн 14 насандаа Аж үйлдвэрийн комбинатад ажилчин болж, улмаар 18 насандаа олзны япончуудыг даргалан ажиллаж, 20-иодхон насандаа Аж үйлдвэрийн комбинатын ерөнхий механик, орлогч даргын албыг залгуулсан гээд эгэл амьдралын эгэл бус нэгэн байсныг зохиолч А.Амарсайханы “Арван дөрөвтэй том хүн” номонд элдэв хачиргүйгээр баримтат уран зохиолын аргаар

өгүүлжээ. Уг номын гол баатар Г.Доржсүрэн гуай өдгөө 87 настай сэрүүн тунгалаг “Арван дөрөвтэй том хүн” номын нээлтэд том охиныхоо хамт хүрэлцэн ирсэн юм. А.Амарсайханы аав Алтангэрэл гуай номын нээлтийн ёслол дээр хүүгийнхээ туурвисан бүтээлийн гол баатар болох Г.Доржсүрэн гуайд алд цэнхэр хадаг өргөн барьж, хүндэтгэл үзүүлсэн.

Дөнгөж саяхан гарсан “Арван дөрөвтэй том хүн” ном бол “Хүмүүн цадиг” цувралын тэргүүн дэвтэр аж. Уг цувралаа эхлүүлэхээр А.Амарсайхан зохиолч сонин содон амьдралтай хүн асууж, сураглаж, судалгаа хийж байхдаа Хэвлэлийн хүрээлэнгээр санаандгүй ортол МУСГЗ Н.Дариймаа багш Г.Доржсүрэн гуайн тухай ярьсан. Анхны ярилцлагаас л гол баатрын өнгөрүүлсэн амьдрал гайхамшигтай санагдаж, ярианд нь өөрийн эрхгүй шимтсэн гэнэ. Анхандаа “Арван дөрөвтэй том хүн” цадигийн гол баатар Гомбын Доржсүрэн өөрийнх ▶

► нь амьдралаар ном бичнэ гэсэн чинь халгаадаггүй. Нэлээд ятгасны эцэст цадигийн номоо бичихээр болсон талаараа А.Амарсайхан ах хуучилсан юм.

Гайхам содон амьдрал туулж, энгүй ихийг бүтээсэн хэрнээ эгэл даруу амьдардаг хүн олон. Ийм хүмүүстэй уншигчдыг уулзуулахаар “Хэцүү анги”, “Тусгай салаа”, “Огцом эргэлт”, “Улаан эрэг” хэмээх олон ангит киногоороо үзэгч олныг байлдан дагуулсан зохиолч А.Амарсайхан ах маань “Хүмүүн цадиг” цувралаа ийнхүү эхлүүлээд байгаа нь энэ аж. Тэрбээр “Түүхийн ном зохиолын хуудсанд улс төрч, төрийн зүтгэлтнүүд, сод хүмүүсийн тухай баримтууд дүүрэн хэрнээ энгийн ардын амьдрал ахуй ямар байсныг ховор дурьдаж үлдээдэг юм билээ. Дарга нарын албан тушаалд очсон он сар өдрийг ягштал тоочсон атлаа энгийн ажилчин талхаа хэдэн төгрөгөөр авдаг байсан талаар нэг ч үг үсэг бичээгүй байдаг. Үүнээс нь болоод адрах сэтгэл төрсөн. “Яахаараа энгийн ажилчин хүний туулсан амьдралаар намтар цадигийн ном гаргаж болдоггүй билээ? Тэгэх тусам нь гайхаж алмайртал нь гоё бичих юм шүү” гэж зүрх сэтгэлдээ асаж шатаж байж л энэхүү “Арван дөрөвтэй том хүн” номоо бичлээ” гэсэн юм.

Амарсайхан ах мөн манай “Mongolian Economy” сэтгүүлийн “ажилтан” бидний туурвисан эдийн засгийн хүнд хэцүү, тоо ихтэй нийтлэл, сэтгүүлийн хуудсыг шог зургаар чимэглэдэг. Мөн түүний хөтөлдөг манай сэтгүүлийн мэдээний нүүрний шог зургийн буланг уншигчид сонирхох дуртай.

“Mongolian Economy” сэтгүүлийг үүсгэн байгуулагдах цагаас эхлээд өнөөдрийг хүртэл үнэнч ажиллаж байгаа зохиолч, сэтгүүлч, шог зураач, багш гээд олон ажлыг зэрэг амжуулдаг Амараа ахдаа манай хамт олон халуун баяр хүргэж, цаашдын уран бүтээлд нь өндөр амжилт хүсье. ■

# MONGOLIAN ECONOMY

РЕДАКЦИД  
ЗАХИАЛБАЛ  
ХҮРГЭЛТ  
ҮНЭГҮЙ

## III УЛИРЛЫН НЭМЭЛТ ЗАХИАЛГА ЯВАГДАЖ БАЙНА

УТАС: 7011-5476

[www.mongolianeconomy.mn](http://www.mongolianeconomy.mn)

## БОДЛОГО, ШИЙДВЭР

## БИДНИЙ ХҮСЭЖ БУЙ ИРЭЭДҮЙ

## Б.ТОГТОХ

Монгол Улс Ногоон хөгжлийн үзэл баримтлалтай боллоо. Жилийн өмнө Улаанбаатар хотноо Дэлхийн байгаль орчны өдрийг тэмдэглэх үеэр Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюун “Монгол Улс ногоон хөгжлийн үзэл баримтлалтай болно” хэмээн мэдэгдэж байсан юм. Тэгвэл энэ оны зургадугаар сарын 13-нд УИХ-ын чуулганы хуралдаанаар “Ногоон хөгжлийн үзэл баримтлал, дунд хугацааны хөтөлбөр батлах тухай” тогтоолын төслийг баталж, Ногоон хөгжлийн бодлого хоёр үе шаттай хэрэгжихээр боллоо. Эхний үе шат буюу Ногоон хөгжлийн үндсийг тавих үе 2014-2020 он бол Ногоон хөгжилд шилжих хоёр дахь үе 2021-2030 он.

Ногоон хөгжлийн бодлого нь цаашдаа Монголын хөгжлийн тулгуур бодлого болох аж. Эдийн засгийн өсөлт нь зайлшгүй байдлаар байгаль орчны доройтлыг дагуулах учиртай гэж өнөөгийн хүн төрөлхтөн үзэхээ нэгэнт больсон. Технологиын дэвшлийн түвшин, ногоон хөгжлийн үзэл баримтлал нь эдийн засгийн өсөлтийг хангахдаа байгальд ээлтэй, хариуцлагатай аргаар нөөцийг ашиглаж хүрээлэн байгаа орчноо хамгаалах юм. Ингэснээр ногоон эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэн экологийн тэнцвэртэй, аюулгүй орчинд амьдрах боломжийг бодит үйл хэрэг болгон хувиргах аж.

Дэлхий нийтэд тулгараад буй уур амьсгалын өөрчлөлт, эдийн засаг, хүн амын хурдацтай өсөлт, хэрэглээ, үйлчилгээний хэт өсөлт, байгалийн нөөцийн хомсдол нь дэлхийн “тусгаар тогтнол”-д эрсдэл учруулах болсон. Өнөөгийн үйлдвэрлэл, хэрэглээний экологийн ул мөрийг тооцоолж үзэхэд энэ хандлагаар цааш хөгжвөл 2030 он гэхэд дэлхийн нөөц боломжоос хоёр дахин давахаар байна. Иймд дэлхийн улс орон, иргэн бүр өөрийн ахуй амьдрал, үйлдвэрлэл, хэрэглээнийхээ хэв маягийг эрс өөрчилж байгальд ээлтэй, “ногоон” хэв загварт шилжих шаардлагатай болж байна.

Жил бүр дэлхийн хүн ам 1.3 тэрбум тонн буюу нийт үйлдвэрлэж буй хүнснийхээ гуравны нэгийг хаяж байна. Барууны өндөр хөгжилтэй орнуудад жилд 220 сая тонн хоол хаядаг аж. Энэхүү хаягдал нь Африкийн Сахарын бүсийн орнуудын үйлдвэрлэж байгаа хүнсний хэмжээтэй /230 сая тонн/ тэнцэж байгаа юм. Хоолны хаягдлыг булж устгадгаас метан хий ялгаруулж, улмаар хүлэмжийн хийг нэмэгдүүлдэг аж. Энэ нь дэлхий нийтийн өмнө тулгамдсан асуудлын нэг болоод байна.

Байгаль орчин, ногоон хөгжлийн дэд сайд Б.Тулга “Улс орон бүр өөрсдийн хөгжлийн чиг хандлагаа хэмнэлттэй ашиглалт, үр дүнтэй үйлдвэрлэлд хандуулж шинэчилж байна. НҮБ-аас баталсан Мянганы хөгжлийн зорилтын хугацаа ирэх онд дуусч байгаа. Залгуулаад Тогтвортой хөгжлийн бодлогыг тодорхойлж буй энэ үед манайх Ногоон хөгжлийн бодлогоо батлууллаа. Монгол Улс ногоон хөгжлийн замаар хөгжих бололцоог хууль эрх зүйн орчин олгож байна. Эхлээд хөгжье, дараа нь цэвэрлэе гэсэн уламжлалт хандлага хэдийнэ хоцрогдсон. Харин хөгжье, хөгжихдөө хамгийн зөв замаар явья гэсэн шинэ хандлага бий болсон” гэв.

Манай улсын хувьд газар нутгийн дийлэнх хэсэг нь харьцангуй байгалийн унаган төрхөө хадгалсан. Түүнчлэн байгалийн арвин нөөц баялаг, газар зүйн байршил, байгаль орчиндоо зохицон амьдрах чадвар, соёл, уламжлалын том давуу талтай. Үүнийгээ ашиглах замаар ногоон хөгжлийн үндсийг бүрдүүлэх боломжтойг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын зөвлөх, доктор Т.Чулуун онцолж байсан. Нөгөө талаар ядуурлын түвшин, орлогын тэгш бус хуваарилалт, байгалийн нөөцөд тулгуурласан эдийн засгийн бүтэц, эрчим хүч болон бусад нөөц баялгийн үр ашиггүй, үрэлгэн хэрэглээ, техник технологийн хоцогдол, уур амьсгалын өөрчлөлтөд өртөмтгий эмзэг байдал зэрэг нь бидэнд томоохон сорилт, бэрхшээл болж буй. ▶



▶ Ногоон хөгжлийн бодлого нь,

- Нөөцийг хэмнэлттэй, үр ашигтай зохистой ашиглах
- Ногоон хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн салбарын бодлого, төлөвлөлтийг хийх,
- Цэвэр дэвшилтэт технологийг дэмжих,
- Ногоо эдийн засгийн өсөлтийг бий болгоход иргэдийн оролцоог хангах,
- Байгальд ээлтэй хандлага, зөв дадлыг төлөвшүүлэх,
- Ил тод, хариуцлагатай, хяналттай байх гэсэн дээрх зарчмыг баримтлах аж. Харин Монгол Улс ногоон хөгжлийг хангахад зургаан стратегийн зорилтыг хэрэгжүүлэх юм.

1. Байгалийн нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарал, хаягдал багатай үйлдвэрлэл, хэрэглээг хөгжүүлнэ. Энэ хүрээнд эрчим хүчний үйлдвэрлэл, аж үйлдвэрийн технологийг шинэчлэн үрэлгэн хэрэглээ, алдагдлыг бууруулах, үнийн бодлогыг оновчтой болгох замаар эрчим хүчний үр ашгийг 2030 он гэхэд 20 хувь нэмэгдүүлж, эрчим хүчний үйлдвэрлэлд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг 2020 он гэхэд 20 хувь, 2030 он гэхэд 30 хувьд хүргэж тус салбарт ногдох хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах аж. Мөн барилгын дулааны алдагдлыг 2020 онд 20 хувь, 2030 онд 40 хувиар тус тус бууруулахаар үйл ажиллагааны чиглэлээ тодорхойлжээ.
2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэн орчны бохирдол, доройтлыг бууруулж, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална. Энэ хүрээнд цэнгэг усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн 60-аас доошгүй хувийн тусгай хамгаалалтад авч, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 2020 онд нийт нутаг дэвсгэрийн 25 хувь, 2030 онд 30 –аас доошгүй хувьд хүргэж, хамгаалалтын тогтвортой санхүүжилтийн тогтолцоо бүрдүүлэх аж. Мөн ойжуулах ажлыг эрчимжүүлж, ойгоор бүрхэгдсэн талбайг 2030 онд нийт газар нутгийн есөн хувьд хүргэж, нүүрсхүчлийн хийн шингэлтийг нэмэгдүүлэх ажлыг хийх юм.
3. Ногоон эдийн засгийг дэмжих санхүүжилт, татвар, зээл, урамшууллын оновчтой хөшүүргийг нэвтрүүлж, байгаль хамгаалал, хүний хөгжил, цэвэр технологийг дэмжих хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ. Энэхүү зорилтод хүрэхийн тулд ДНБ-ий хоёроос доошгүй хувийг жил бүр ногоон хөгжилд зарцуулж, нэгж бүтээгдэхүүнд ногдох нүүрсхүчлийн хийн ялгарлыг бууруулах, бүтээмжийг дээшүүлэх, байгалийн нөөц ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтыг өсгөх аж. Мөн Засгийн газрын худалдан авалтын 20-оос доошгүй хувийг байгаль орчинд ээлтэй, үр ашигтай, хэмнэлттэй бараа, ажил, үйлчилгээ авахад зарцуулахаар үйл ажиллагааны чиглэлд тусгасан байна.
4. Ногоон ажил эрхлэлтийг дэмжиж, ядуурлыг бууруулан ногоон амьдралын хэв маягийг

төлөвшүүлнэ. Энэхүү зорилт нь Олон улсын жишигт нийцсэн чанартай боловсролыг эх орондоо эзэмшиж, өрсөлдөх чадвартай, мэргэшсэн чадварлаг ажиллах хүчинтэй болж, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэхээр замаар биелэх юм.

5. Байгальд зохицсон ахуй, соёлын үнэт зүйлсийг хөгжүүлж, боловсрол, шинжлэх ухаа технологи, инновацийг ногоон хөгжлийн хурдасгуур болгоно. Уг зорилтод хүрэх үүднээс Ногоон хөгжлийг дэмжсэн цэвэр технологи, инновацийг хөгжүүлж, шинжлэх ухаан технологийн судалгаа, туршин нэвтрүүлэх санхүүжилтийг 2020 онд ДНБ-ий хоёр хувь, 2030 онд гурван хувьд хүргэх аж.
6. Уур амьсгалын өөрчлөлт, бүс нутгийн байгалийн нөөц баялаг, сэргэх чадавхид нийцүүлэн хүн амын суурьшлыг төлөвлөн хөгжүүлнэ. Энэхүү зорилтын хүрээнд хэд хэдэн ажлыг хийхээр төлөвлөжээ. Тухайлбал, хог хаягдлыг боловсруулж дахин ашиглах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгальд булж зайлуулах хаягдлын хэмжээг 2020 онд 20, 2030 онд 40 хувь тус тус бууруулах юм байна. Үүнээс гадна хүн амын хэт төвлөрөл үүсэхээс сэргийлсэн, өөрийгөө тэтгэх чадвартай “ногоон”, “ухаалаг” жижиг хот, тосгоны хөгжүүлж, орон нутагт тав тухтай ажиллаж, амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх юм.

Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн Х.Хишигжаргал “Ногоон хөгжлийн баримт бичиг нь ганцхан Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны хэрэгжүүлэх асуудал биш салбар дундын зохицуулалтыг хангасан урт хугацааны бодлогын баримт бичиг. Байгалийн нөөцөд тулгуурласан эдийн засагтай манай улс цаашид байгалийн нөөцөө урт хугацаанд тогтвортой ашиглаж, үр өгөөжийг нь ард иргэддээ тэгш хүртээхийн тулд зайлшгүй байгалийн нөөцөө үр ашигтай хэмнэлттэй ашиглах замаар байгалийн нөөцдөө эргүүлээд хөрөнгө оруулах гэсэн бодлогын үзэл баримтлал бүх байгалийн нөөцөд тулгуурласан салбаруудын үйл ажиллагаанд хэрэгжүүлэх ёстой гол зарчим” гэв.

Төрөөс баримтлах Ногоон хөгжлийн бодлоготой болохын сацуу Монгол Улс “Даян дэлхийн ногоон өсөлтийн байгууллага”-ын албан ёсны гишүүн боллоо. Ногоон хөгжлийн бодлогыг тодорхойлсон Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюун НҮБ-ын Байгаль орчны Ассамблейн даргаар томилогдсон гээд шил шилээ дарсан үйл явдал өрнөв. “Бидний хүсэж буй ирээдүй” сэдвийн дор 2012 онд болж байсан Рио+20 бага хурлын үеэр ногоон эдийн засаг нь тогтвортой хөгжилд хүрэх, ядуурлыг бууруулах гол арга зам хэмээн тунхагласан байдаг. Энэхүү тунхаглалыг НҮБ-аас дэмжин “Ногоон эдийн засгийн төлөөх үйл ажиллагааны түншлэл”-ийн хүрээнд хамтран ажиллах эхний долоон загвар орны нэгээр Монгол Улс сонгосон билээ. Ээлтэй бодлого эдийн засагт хэрэгжих нөхцөл бүрджээ. ■